



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



From  
the People of Japan



Боловсролын  
Хамтын Ажиллагааны  
Нийгэмлэг

# ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛ

БОДЛОГЫН ХУРААНГУЙ

Улаанбаатар  
2023



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



# ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛ

## БОДЛОГЫН ХУРААНГУЙ

Улаанбаатар

2023 он

Бодлогын энэхүү хураангуйг Боловсрол, шинжлэх ухааны яам Азийн Хөгжлийн Банктай хамтран Цэцэглэн хөгжсөн, сөрөг нөлөөнд тэсвэртэй Ази, Номхон далайн бүс нутгийг цогцлоох Японы сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй "Тэгш хамруулах боловсролыг дэмжих" төслийн хүрээнд боловсруулан хэвлүүлэв.

© Боловсрол, шинжлэх ухааны яамны зөвшөөрөлгүй хувилж, дахин хэвлэхийг хориглоно.

**Боловсруулсан:**

Тэгш хамруулах боловсролыг дэмжих төслийн олон улсын зөвлөх, доктор  
Паула Ф. Хант

**Хянан тохиолдуулсан:**

А.Цолмон  
Б.Болорчимэг

## АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	4
ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ БОДЛОГЫН ХУРААНГУЙ	6
● Боловсрол эзэмших эрх	6
● Тэгш хамрагдан сурч боловсрох эрх	11
● Тэгш хамран сургах боловсролын үндсэн шинж	14
● Ерөнхий зөвлөмжийн бусад бүрэлдэхүүн	15
● Тэгш хамран сургах боловсролын үр өгөөж	18
● Хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ	19
МОНГОЛ УЛС ДАХЬ ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ БОДЛОГЫН ХУРААНГУЙ	22
● Сурч боловсрох эрх Монгол Улсад	22
● Тэгш хамрагдан сурч боловсрох эрх	28
● Тэгш хамрагдан сурч боловсрох эрх Монгол Улсад	30
● Зөвлөмж	38

## ӨМНӨХ ҮГ

Боловсрол бол хүний суурь эрхүүдийн нэг бөгөөд улс орон бүр хүүхэд нэг бүрийн сурч боловсрох эрхийг хангах үүрэг хүлээдэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын Ерөнхий зөвлөмж 4-т<sup>1</sup> тэгш хамран сургах боловсролыг “Сурч боловсрох эрхийг эдлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг арилгахад чиглэсэн тасралтгүй бөгөөд идэвхтэй үүрэг амлалт бүхий үйл явцын төдийгүй бүх суралцагчдыг үр дүнтэй байдлаар тэгш хамруулах чиглэлээрх ердийн сургуулиудын хэвшмэл соёл, бодлого болон өдөр тутмын практик үйл ажиллагаагаа өөрчилснөөр хүрэх үр дүн” хэмээн ойлгоно гэжээ. Тус конвенц болон түүний Ерөнхий зөвлөмж 4-т улс орнууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрийн амьдран суугаа газар нутагтаа бусдын адил бага, дунд сургуульд элсэн суралцах боломжтой байх болон тусгай сургалтын байгууллагад элсэн суралцуулах зорилгоор тэднийг гэр орноос нь холдуулан тусгаарлахгүй байх явдлыг баталгаажуулах үүрэг хүлээнэ гэж заасан.

Гэвч дэлхий нийтэд 258 сая хүүхэд, өсвөр үеийнхэн болон залуучууд<sup>2</sup>, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид сургуулийн гадна байгаа ба дөрвөн улс тутмын нэг нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг бусдаас тусгаарлан тусгай сургуульд суралцуулахыг заасан бодлого<sup>3</sup> болон практик үйл ажиллагааг хэрэгжүүлсээр байна. Монгол Улсын сургуулийн өмнөх, бага болон суурь боловсролын хамран сургалтын хувь харьцангуй өндөр түвшинд хүрсэн бөгөөд нэлээд хугацаанд тогтвортой байгаа ба 2022-2023 оны хичээлийн жилийн байдлаар тус тус 86.5%, 96.5% ба 94.0%<sup>4</sup> байна. Гэвч хөгжлийн бэрхшээлтэй охид, хөвгүүд болон ядуу өрхийн хүүхдүүд зэрэг тодорхой бүлгийн хүүхдүүдийн хувьд тэгш хамруулсан чанартай боловсролын үйлчилгээнд хамрагдахад нь олон төрлийн саад бэрхшээл тулгарсан хэвээр байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын чанар, хүртээмжийг сайжруулахад Боловсрол, шинжлэх ухааны яам Азийн Хөгжлийн Банктай хамтран Цэцэглэн хөгжсөн, сөрөг нөлөөнд тэсвэртэй Ази, Номхон далайн бүс

1 Нэгдсэн Үндэстний Байгууллага. 2016. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаарх асуудал хариуцсан хороо Ерөнхий зөвлөмж No. 4 (2016) Тэгш хамран сургах боловсрол эзэмших эрх. CPRD/C/GC 4. Женев.

2 ЮНЕСКО. 2020. Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлангийн хураангуй 2020: Тэгш хамруулалт ба боловсрол: Бүх нийт гэсэн бол бүх нийт л байх ёстой. Парис, ЮНЕСКО.

3 ЮНЕСКО. 2020. Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлангийн хураангуй 2020: Тэгш хамруулалт ба боловсрол: Бүх нийт гэсэн бол бүх нийт л байх ёстой. Парис, ЮНЕСКО.

4 Боловсрол, шинжлэх ухааны яам, 2023. Боловсролын салбарын статистикийн мэдээлэл 2022-2023. Улаанбаатар.

нутгийг цогцлоох Японы сангийн 2 сая ам. долларын буцалтгүй тусламжаар “Тэгш хамруулах боловсролыг дэмжих” төслийг 2021-2024 онд хэрэгжүүлж байна. Төсөл дараах гурван бүрэлдэхүүн хэсэгтэй:

**Үр дүн 1.**

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн дэд бүтцийг сайжруулж, илүү хүртээмжтэй болгох

**Үр дүн 2.**

Тэгш хамран сургах боловсролын үйлчилгээг хүргэх чадавхыг бэхжүүлэх

**Үр дүн 3.**

Тэгш хамран сургах боловсролыг дэмжих нөөц боломж, олон нийтийн оролцоо болон бодлогын орчныг сайжруулах

Төслийн хүрээнд 2022 онд Монгол Улс дахь тэгш хамран сургах боловсролын талаарх хууль тогтоомж, бодлого болон өмнөх жилүүдэд гарсан холбогдох тайлангуудыг судалж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын Ерөнхий зөвлөмж 4-т тодорхойлсон тэгш хамран сургах боловсролын есөн үндсэн шинж чанарын хүрээнд дүн шинжилгээ хийж, ерөнхий тайлан болон дараах хоёр бодлогын хураангуйг бэлтгэлээ:

- 1. Тэгш хамран сургах боловсролын талаарх бодлогын хураангуй:** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын Ерөнхий зөвлөмж 4, Тогтвортой хөгжлийн зорилго 4 дагаж мөрдөх нь
- 2. Монгол Улс дахь тэгш хамран сургах боловсролын талаарх бодлогын хураангуй:** Хууль тогтоомж, бодлогод хийсэн дүн шинжилгээний үр дүнгийн талаарх зөвлөхийн тайлангийн тойм

Бид “тэгш хамран сургах боловсрол” гэсэн нэр томъёог бүхий л суралцагчдад боловсролын үйлчилгээг гэр орных нь ойролцоох цэцэрлэг, сургуулиар дамжуулан ялгаварлалгүй хүргэдэг, аливаа суралцагчийн боловсролын орчин дахь хамрагдалт, оролцоо, амжилтад саад болж болзошгүй бэрхшээлүүдэд дүн шинжилгээ хийхэд онцгойлон төвлөрдөг боловсрол гэсэн өргөн утгаар нь авч үзлээ.

Бодлогын зөвлөмжийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын Ерөнхий зөвлөмж 4, Португал, Латви улсуудын сайн туршлагад суурилан боловсруулав. Монгол Улсын боловсролын бодлого боловсруулагчид болон бодлогыг хэрэгжүүлэгч бүх оролцогч талууд бодлогын зөвлөмжийг уншин судалж, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэхийг хичээнгүйлэн хүсье.

ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

## ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ БОДЛОГЫН ХУРААНГУЙ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ  
КОНВЕНЦЫН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ 4,  
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО 4 ДАГАЖ МӨРДӨХ НЬ

Хүний сурч боловсрох эрхийн асуудал 1948 оноос хойш олон улсын үүрэг хариуцлагад тусгагдсаар иржээ. Цаг хугацаа өнгөрөх тусам тэгш хамран сургах практик үйл ажиллагаа хэрэгжүүлэхтэй холбогдсон хууль тогтоомж, бодлогын баримт бичиг дэлхийн хэмжээнд нэмэгдсэн хэдий ч 2018 оны байдлаар 258 сая орчим хүүхэд, залуус сургуулийн гадна үлдсэн хэвээр байна.<sup>1</sup> Түүнээс гадна КОВИД-19 цар тахал нөхцөл байдлыг улам доройтуулсныг баримт бичгийн үндсэн дээр баталгаажуулсан<sup>2&3</sup> бөгөөд нийгмийн эмзэг бүлгийн хүүхдүүдийн тэгш хамрагдан сурч боловсрох эрх 2022 онд сайжирсан гэхээс илүү доройтсон хэмээн үзэж байна.

### Боловсрол эзэмших эрх

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын<sup>4</sup> 26 дугаар зүйлд “Хүн бүр сурч боловсрох эрхтэй. Бага боловсрол заавал эзэмших, үнэ төлбөргүй байна” хэмээн тунхагласан билээ. Боловсролыг энх тайван, хөгжил цэцэглэлтэд хүрэх арга зам хэмээн үзэх тул дээд боловсрол, техникийн болон мэргэжлийн боловсрол ч хүртээмжтэй байх бөгөөд боловсрол нь бие хүнийг хөгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх

1 <http://uis.unesco.org/en/topic/out-school-children-and-youth>

2 Армитэйж, Р., & Неллумс, Л. Б. (2020). КОВИД-19 цар тахлын үед сургууль хаагдсаны улмаас үүссэн тэгш бус байдлыг харгалзан үзэх нь. Лансет Дэлхийн Эрүүл мэнд, 8 (5), e644 [https://doi.org/10.1016/S2214-109X\(20\)30116-9](https://doi.org/10.1016/S2214-109X(20)30116-9) (Armitage, R., & Nellums, L. B. (2020). Considering inequalities in the school closure response to COVID-19. The Lancet Global Health, 8(5), e644. [https://doi.org/10.1016/S2214-109X\(20\)30116-9](https://doi.org/10.1016/S2214-109X(20)30116-9))

3 Ван Ланкер, В., & Паролин, З. (2020). КОВИД-19, сургууль хаагдсан ба хүүхдийн ядуурал: Нийгэмд хямрал үүсэж байна. Лансет Дэлхийн Эрүүл мэнд, 5(5), e243–e244. [https://doi.org/10.1016/S2468-2667\(20\)30084-0](https://doi.org/10.1016/S2468-2667(20)30084-0) (Van Lancker, W., & Parolin, Z. (2020). COVID-19, school closures, and child poverty: A social crisis in the making. The Lancet Public Health, 5(5), e243–e244. [https://doi.org/10.1016/S2468-2667\(20\)30084-0](https://doi.org/10.1016/S2468-2667(20)30084-0))

4 НҮБ-ын Ерөнхий Ассемблей, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1948 оны 12 дугаар сарын 10, 217 А (III), <https://www.refworld.org/docid/3ae6b3712c.html> [2022 оны 6 дугаар сарын 7-нд тус холбоосоор мэдээлэл авсан] (UN General Assembly, Universal Declaration of Human Rights, 10 December 1948, 217 A (III), available at: <https://www.refworld.org/docid/3ae6b3712c.html> [accessed 7 June 2022])

явдлыг бэхжүүлэхэд чиглэх ёстой гэж үзсэн. “Боловсрол нь аливаа үндэстэн, арьс өнгө, шашны бүлгүүдийн хоорондын харилцан ойлголцол, хүлээцтэй байдал, нөхөрлөлийг дэмжиж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын үйл хэргийг урагшлуулах болно” гэжээ.

1989 онд баталсан Хүүхдийн эрхийн тухай конвенц<sup>5</sup> хүүхдийн эрхийг нийгэм, эдийн засаг, соёл, иргэн, улс төр, хамгааллын үүднээс авч үзсэнээс гадна хүн бүрийн сурч боловсрох эрхийг дэмжсэн юм. Энэ конвенц нь хүүхдийн үзэл бодлыг харгалзан үзэх ёстойг тусгасан олон улсын анхны гэрээ бөгөөд тэгш боломжийн үндсэн дээр боловсрол эзэмших эрх болон хүүхдийн чадавхыг бүрэн дүүрэн хөгжүүлэхэд чиглэсэн боловсролын үндсэн зорилгын аль алиныг онцолсон байдаг. Тухайлбал, хүүхэд бүрийн бүх эрхийг ямар нэгэн ялгаварлан гадуурхал, тэр дундаа хөгжлийн бэрхшээлд үндэслэсэн ялгаварлан гадуурхлаас ангид хэрэгжүүлэх тухайлсан үүрэг хариуцлагыг анх удаа улс орнуудын Засгийн газарт хүлээлгэсэн (2 дугаар зүйл). Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн амьдралд үр дүнтэй оролцох боломжийг бүрдүүлэх, боловсролын үйлчилгээнд хамрагдах явдлыг баталгаажуулах зорилгоор туслалцаа авах эрхийг ч тусгажээ (23 дугаар зүйл).

Хүүхдийн эрхийн тухай конвенц батлагдсаны дараа 92 улсын Засгийн газар, олон улсын 25 байгууллагын төлөөлөгчид Саламанкагийн тунхаглал, үйл ажиллагааны хүрээ<sup>6</sup> хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр 1994 онд баталсан. Энэхүү баримт бичигт тэгш хамран сургах боловсролын асуудлыг анх удаа хөндсөн. Уг баримт бичгийг олон улсын хэмжээнд заавал дагаж мөрдөх ёсгүй ч бие бялдар, оюун ухаан, нийгэм, сэтгэл хөдлөл, хэл болон бусад нөхцөл байдлаас үл хамааран ердийн сургуулиуд бүх хүүхдийг хүлээн авч сургах талаар санал нэгдсэн болохыг баримт бичигт тусгажээ. Түүнчлэн боловсролын бүхий л бодлогод хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд “хөгжлийн бэрхшээлгүй байсан бол хамрагдах ёстой байсан” гэрийнхээ ойролцоох тэр л сургуульд суралцах явдлыг баталгаажуулах ёстойг онцолсон байна.

5 НҮБ-ын Ерөнхий Ассемблей, Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1989 оны 11 дүгээр сарын 20, Нэгдсэн Үндэстний Байгууллага, Гэрээ хэлэлцээрийн цуврал, цуврал.1577, 3 дахь тал, холбоос: <https://www.refworld.org/docid/3ae6b38f0.html> [2022 оны 6 дугаар сарын 7-нд тус холбоосоор мэдээлэл авсан] (UN General Assembly, Convention on the Rights of the Child, 20 November 1989, United Nations, Treaty Series, vol. 1577, p. 3, available at: <https://www.refworld.org/docid/3ae6b38f0.html> [accessed 7 June 2022])

6 НҮББШУСБ. (1994). Саламанкагийн тунхаглал ба Тусгай хэрэгцээт боловсролын талаарх үйл ажиллагааны хүрээ. (UNESCO. (1994). The Salamanca Statement and Framework for Action on Special Needs Education.)



Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц<sup>7</sup> 2008 онд батлагдсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр бусад хүний нэгэн адил хүний бүх эрх, эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх ёстой тул уг конвенц шинэ эрхийг тунхаглаагүй. Харин өмнө нь тунхагласан эрхүүдийг дахин баталгаажуулж, тэдгээрийн хэрэгжилтийг хангах нэмэлт үүргийг улс орнуудын Засгийн газарт хүлээлгэсэн.

Тиймээс энэ конвенцоор “Боловсролын бүхий л түвшинд тэгш хамран сургах тогтолцоог” хангахын тулд сурч боловсрох эрхийн (24 дүгээр зүйл) талаар нарийвчилсан заалтыг багтаажээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц нь тэгш хамран сургах боловсролыг эрх хэмээн онцлон дэмжсэн олон улсын түвшний эрх зүйн анхны акт юм. Түүнчлэн конвенц нь олон улсын өмнөх гэрээнүүдэд үндэслэн хүний бүх эрхийг хамгаалах Засгийн газруудын үүргийг тодотгож, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг арилгах үүрэг хариуцлагыг шинээр хүлээлгэсний зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг эрхээ хангуулахын төлөө дуу хоолойгоо илэрхийлэх, илүү үр дүнтэйгээр хамгаалагдах явдлыг баталгаажуулахыг онцолсон. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцод зааснаар:

*Оролцогч улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү эрхийг ямарваа нэг ялгаварлалгүй, тэгш боломжийн үндсэн дээр хангах бөгөөд оролцогч улсууд нь боловсролын бүх түвшинд болон насан туршийн суралцахуйн үйл явцад дараах зорилгод чиглэсэн тэгш хамран сургах боловсролын тогтолцоог баталгаажуулах үүрэг хүлээнэ (24 дүгээр зүйл):*

- а) хүний чадвар, чадамжийг бүрэн дүүрэн хөгжүүлэх;*
- б) хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийн шинж чанар, авьяас чадвар, бүтээлч чанар болон тэдний оюуны болон бие махбодын чадварыг байж болох хамгийн боломжит дээд хэмжээгээр хөгжүүлэх;*
- в) чөлөөт нийгэмд үр дүнтэйгээр оролцох боломжийг олгох.*

Дээр дурдсан эрхийг хэрэгжүүлэх үүднээс конвенцод нэгдэн орсон улс орнуудын Засгийн газар дараах үүрэг хүлээнэ:

- ялгаварлалаас ангид, тэгш боломжид суурилсан сурч боловсрох эрхийг баталгаажуулах;

<sup>7</sup> НҮБ-ын Ерөнхий Ассемблей, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц: шийдвэр / Ерөнхий Ассемблейгээс баталсан, 2007 оны 1 дүгээр сарын 24, A/RES/61/106, холбоос: <https://www.refworld.org/docid/45f973632.html> [2022 оны 6 дугаар сарын 7-нд тус холбоосоор мэдээлэл авсан] (UN General Assembly, Convention on the Rights of Persons with Disabilities: resolution / adopted by the General Assembly, 24 January 2007, A/RES/61/106, available at: <https://www.refworld.org/docid/45f973632.html> [accessed 7 June 2022])

- боловсролын бүх түвшинд тэгш хамран сургах тогтолцоог бий болгох;
- тохируулгат хэрэглэгдэхүүн, орчин болон хувь хүний онцлог, шаардлагад нийцсэн ганцаарчилсан дэмжлэг үзүүлэх үйлчилгээгээр хангах;
- боловсрол болон нийгмийн амьдралд тэгш оролцоход шаардлагатай ур чадвар эзэмших боломжоор хангах;
- тохирох ур чадвар бүхий мэргэшсэн багш нараар хангах;
- тэгш хамран сургах боловсролыг ахиц дэвшилтэйгээр бүрэн хэрэгжүүлэх.

Ази, Номхон далайн бүс нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг бодит болгоё” Инчоны стратеги буюу Ази, Номхон далайн бүс нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөх арван жил (2013-2022)-ийн талаарх Сайд нарын тунхаглалд Ази, Номхон Далайн бүсийн эдийн засаг, нийгмийн асуудлын хорооны төлөөлөгчид 2012 онд гарын үсэг зурсан билээ. Энэ стратеги нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралыг сайжруулахад чиглэсэн шинэ арван жилийн үйл хэргийг бүс нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх үүрэг амлалтыг тодорхойлж, “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст холбогдох асуудлыг тэгш хамруулсан бүс нутгийн хэмжээнд тохирсон хөгжлийн зорилтууд” бүхий зааварчилгаагаар хангасан юм. Мөн улс орнуудын Засгийн газар, иргэний нийгмийн оролцогч талуудтай хоёр жил гаруйн хугацаанд зөвлөлдсөний үр дүнд боловсруулсан Инчоны тунхаглал нь 10 зорилго, 27 хүрэх үр дүн, 62 шалгуур үзүүлэлтээс бүрджээ”.<sup>8</sup>

2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилго хөтөлбөр<sup>9</sup> 2015 онд батлагдсан. “Тэгш хамран сургах, тэгш боломжийг хангасан чанартай боловсрол, бүх нийтийн насан туршдаа суралцах боломжийг дэмжих” Тогтвортой хөгжлийн зорилго 4 нь тэгш хамрагдан сурч боловсрох эрхийг хангахын тулд хүүхэд бүрийг шаардлагатай нөхцөлөөр хангаж чадах илүү тэгш хамруулсан, тэгш боломжоор хангасан, чанартай боловсролын тогтолцоонд хурдтай шилжих үүрэг хариуцлагыг улс орнуудын Засгийн газарт хүлээлгэсэн.

8 НҮБ-ын АНДБЭЗНАХ (2012) Инчоны стратеги – Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг бодит болгох” 10 зорилго, <https://www.maketherightreal.net/incheon-strategy/introduction> холбоосоор 2022 оны 7 дугаар сарын 5-нд мэдээлэл авсан [UNESCAP (2012) Incheon Strategy – 10 Goals to “Make the Right Real” for persons with disabilities in Asia and the Pacific, retrieved 5 July 2022 <https://www.maketherightreal.net/incheon-strategy/introduction>]


9 НҮБ-ын Ерөнхий Ассемблей, Дэлхийг хувирган өөрчлөх нь: Тогтвортой хөгжлийн төлөөх 2030 хөтөлбөр, 2015 оны 10 дугаар сарын 21, A/RES/70/1, холбоос: <https://www.refworld.org/docid/57b6e3e44.html> [2022 оны 6 дугаар сарын 7-нд тус холбоосоор мэдээлэл авсан] (UN General Assembly, Transforming our world: the 2030 Agenda for Sustainable Development, 21 October 2015, A/RES/70/1, available at: <https://www.refworld.org/docid/57b6e3e44.html> [accessed 7 June 2022])

## ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛ ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧИГТ



### Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948)

26 дугаар зүйлд хүн бүр сурч боловсрох эрхтэй бөгөөд бага боловсрол нь заавал эзэмших боловсрол байх ба үнэ төлбөргүй байна хэмээн тунхагласан байдаг.



### Хүүхдийн эрхийн тухай конвенц (1989)

Хүүхэд бүрийн сурч боловсрох зэрэг эрхийг чухалчилж, тэдний үзэл бодлыг харгалзан үзэх ёстойг тусгасан анхны олон улсын акт юм.



### Саламанкагийн тунхаглал (1994)

Тэгш хамран сургах боловсролын тухай анх удаа энэхүү тунхаглалд дурдсан. Ердийн сургуулиуд нь бие бялдар, оюун ухаан, нийгэм, сэтгэл хөдлөл, хэл болон бусад нөхцөл байдлаас үл хамааран бүх хүүхдийг хүлээн авч сургах талаар тусгасан. Улмаар боловсролын бүхий л бодлогод хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд "хөгжлийн бэрхшээлгүй байсан бол хамрагдах ёстой байсан" гэр орныхоо дэргэдэх тэр л сургуульд суралцах явдлыг баталгаажуулах ёстойг тэмдэглэсэн.



### Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц (2008)

"Боловсролын бүхий л түвшинд тэгш хамран сургах тогтолцоог" хангахын тулд сурч боловсрох эрхийн (24 дүгээр зүйл) талаар нарийвчилсан заалтуудыг агуулсан. Энэхүү конвенц нь тэгш хамран сургах боловсролыг эрх хэмээн онцлон дэмжсэн олон улсын түвшний хамгийн анхны хууль эрх зүйн акт юм.



### Тогтвортой хөгжлийн зорилгууд (2015)

Тогтвортой хөгжлийн зорилго 4 нь тэгш хамрагдан сурч боловсрох эрхийг хангахын тулд хүүхэд нэг бүрийг шаардлагатай нөхцөлөөр хангаж чадах илүү тэгш хамруулсан, илүү тэгш боломжоор хангасан бөгөөд илүү өндөр чанартай боловсролын тогтолцоо руу эрчимтэй шилжих үүрэг хариуцлагыг улс орнуудад хүлээлгэсэн.

Тогтвортой хөгжлийн зорилго 4 нь өнгөрсөн хугацаанд баталсан олон улсын гэрээ хэлэлцээр болон хийгдсэн судалгаа, мэдээлэлд суурилсан. 2030 он гэхэд бүх охид, хөвгүүдийг бага насны хүүхдийн хөгжил, асаргаа болон сургуулийн өмнөх боловсролын чанартай үйлчилгээнд хамруулах; үнэ төлбөргүй, тэгш хамарсан, чанартай бага, дунд боловсролын үйлчилгээнд хамруулах, сургалтын үйл ажиллагаанд оролцуулах, сургууль төгсгөх; эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд мэргэжлийн болон дээд боловсрол, техникийн ур чадвар эзэмших, бичиг үсэг, тоо бодох чадварт суралцах тэгш боломж олгох бөгөөд хамгийн чухал нь “бүх хүнд аюулгүй, хүчирхийллээс ангид, тэгш хамруулсан, үр дүнтэй суралцах орчноор хангах, боловсролын байгууллагыг хүүхдэд ээлтэй, хөгжлийн бэрхшээл болон жендэрийн мэдрэмжтэй болгох” үүргийг улс орнуудын Засгийн газарт хүлээлгэсэн (Зорилт 4а).

### ● Тэгш хамрагдан сурч боловсрох эрх

Өнгөрсөн 60 жилийн хугацаанд сурч боловсрох эрхийг хүний салшгүй эрх болгон хэрэгжүүлэхэд ахиц дэвшил гарсан хэдий ч 2015 оны байдлаар нийгмийн эмзэг бүлгийн хүүхдүүдийн боловсролд төдийлөн ахиц гараагүй байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэхэд тэд боловсролын үйлчилгээний гадна үлдсэн байдал хэвээр, хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхах, сургуульд элсэх, сургалтын үйл ажиллагаанд оролцоход болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тулгардаг саад бэрхшээлийн талаар сайн мэдэхгүй, шийдвэр гаргахад шаардлагатай тоон мэдээлэл, судалгаа хангалтгүй, тэгш хамран сургах боловсролын талаар мэдлэг, ойлголт хангалтгүй зэрэг сорилт бэрхшээлүүд байсаар байна.

Иймээс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос “Тэгш хамрагдан сурч боловсрох эрхийн тухай” Ерөнхий зөвлөмж 4<sup>10</sup>-ийг боловсруулахаар шийдвэрлэж, уг зөвлөмжийг 2016 онд баталсан.

Энэхүү зөвлөмж нь тэгш хамран сургах боловсрол гэдэгт юуг ойлгох талаар нэн шаардлагатай тайлбар өгч, тэгш хамран сургах боловсрол нь интеграцчиллаас ямар ялгаатай болохыг тодорхойлсон юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролын гадна үлдээх буюу “суралцагчдад аливаа хэлбэрээр боловсролд хамрагдахад нь шууд болон шууд бусаар саад

10 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороо. (2016). Ерөнхий зөвлөмж No. 4 (2016) 24 дүгээр зүйл—Тэгш хамрагдан сурч боловсрох эрх (Ерөнхий зөвлөмж ХБХЭТК/С/СГ/4). Нэгдсэн Үндэстний Байгууллага. (Committee on the Rights of Persons with Disabilities. (2016). General Comment No. 4 (2016) Article 24—Right to inclusive education (General Comment CRPD/C/GC/4). United Nations.)

учруулах эсхүл тэднийг боловсролд хамрагдахыг хориглох”<sup>11</sup>, мөн “хөгжлийн бэрхшээлгүй сурагчдаас тусад нь тодорхой нэг эсхүл олон төрлийн хөгжлийн бэрхшээлтэй ажиллахад зориулагдсан орчинд сургаж”<sup>12</sup> тусгаарлаж ирсэн уламжлалын хүрээнд интеграцчилал нь практикт өргөн хэрэглэгдэж ирсэн тул тэгш хамран сургах боловсролыг интеграцчилалтай андуурах нь түгээмэл байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороо нь Ерөнхий зөвлөмж 4-т дурдсан дээрх хоёр үзэл баримтлалын ялгааг тодорхой гаргаж, тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэх зураглал гаргасан. Интеграцчиллыг “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ердийн сургуулийн стандартын шаардлагад нийцэн сурах боломжтой тохиолдолд тэднийг эдгээр байгууллагад байршуулах үйл явц”<sup>13</sup> хэмээн тодорхойлсон бол тэгш хамран сургах боловсрол нь соёл, бодлого, өдөр тутмын үйл ажиллагааг хувирган өөрчлөх, саад бэрхшээлийг арилгах болон бүх суралцагчдад хүрч ажиллах боловсролын тогтолцооны чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн үүрэг амлалт юм. Тэгш хамран сургах боловсрол нь бүх суралцагчдыг ялгаварлан гадуурхалгүйгээр тэдний бүрэн дүүрэн үр дүнтэй оролцоо, хамрагдалт, хичээлийн ирц болон ололт амжилтад голлох анхаарал хандуулдаг. Энэ нь боловсролын агуулга, сургалтын арга зүй, арга хандлага, бүтэц, стратегийн өөрчлөлт, шинэчлэлийг агуулсан тогтолцооны шинэчлэлийн үйл явц бөгөөд уг үйл явцыг хэрэгжүүлэхэд оролцогч улс орнууд санхүүгийн болон хүний нөөцийг хангалттай зориулах шаардлагатай.


Тэгш хамран сургах боловсрол нь бүх суралцагчдад чанартай боловсрол эзэмшүүлэхэд нэн чухал ач холбогдолтой бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг хамруулан бүх суралцагчийн хувьд боловсролын бүх түвшинд (сургуулийн өмнөх, бага, дунд, дээд болон мэргэжлийн боловсрол, насан туршийн суралцахуй, хичээлээс гадуурх болон нийгмийн үйл ажиллагаа) ялгаварлалаас ангид, бусадтай адил тэгш байдлын үндсэн дээр боловсрол олгох ёстой.

11 Өмнөхтэй ижил, 4 дэх нүүр, 11 дэх догол мөр

12 Өмнөхтэй ижил


13 Өмнөхтэй ижил

## ТЭГШ ХАМРУУЛАЛТ ГЭЖ ЮУ ВЭ?




### Гадуурхах

Зөвхөн гаднаа адил харагддаг нийгмийн гишүүд нэг "тойрог"-т багтах боломжтой. Бусад гишүүд тойргийн гадна үлддэг.




### Тусгаарлах

Олонхоос өөр нийгмийн гишүүд өөрсдийн тусгай "тойрог"-т байдаг. Энэ тойрог нь олонхын "тойрог"-той хэзээ ч давхацдаггүй.



### Интеграцчилах

Цөөнхийн "тойрог" нь олонхын "тойрог"-ийн дотор багтсан ч хамтын ажиллагаа байхгүй.



### Тэгш хамруулах

ЦОРЫН ГАНЦ "тойрог" байна. Энэ тойрогт ялгаатай байдлаас үл хамааран бүх хүн багтах ба тэд зорилго, үүрэг хариуцлага нэгтэй.

## ● Тэгш хамран сургах боловсролын үндсэн шинж

Тэгш хамран сургах боловсролын тогтолцоонд шилжихэд анхаарах есөн онцлог шинжийг Ерөнхий зөвлөмж 4<sup>14</sup>-т заасан:

1. **“Тогтолцоо бүхэлдээ” арга хандлага:** Боловсролын яамд тэгш хамран сургах боловсролыг хөгжүүлэхэд бүх нөөц боломжоо дайчлах шаардлагатай. Тэгш хамран сургах боловсрол нь хүн бүрд хамааралтай асуудал тул салбар дундын хамтын ажиллагаа, нийгмийн оролцоог хангасан бүтэц, Засгийн газрын түвшний үүрэг амлалтаар дэмжих ёстой.
2. **“Боловсролын орчныг иж бүрнээр нь” авч үзэх:** Боловсролын тогтолцоонд бүхэлд нь соёл, бодлого, өдөр тутмын үйл ажиллагааг хувирган өөрчлөх нь боловсролын удирдах ажилтны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл байх ёстой.
3. **“Хувь хүнийг цогцоор нь” авч үзэх хандлага:** Хүн бүр сурах чадвартайг хүлээн зөвшөөрч, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг бүхий л суралцагчийн хувьд өндөр хүлээлт тавих ёстой. Тэгш хамран сургах боловсрол нь өөр хоорондоо ялгаатай давуу тал, шаардлага, хүсэл эрмэлзэл, суралцах хэв маягт нийцсэн уян хатан сургалтын хөтөлбөр, сургах болон сурах төрөл бүрийн арга зүйд суурилдаг. Сургалтын агуулга гэхээс илүүтэйгээр суралцагчдын чадавх, хүсэл эрмэлзэлд түлхүү анхаарал хандуулдаг.
4. **Багш нарт дэмжлэг үзүүлэх:** Тэгш хамран сургах чанартай боловсролын гол тулгуур нь багш нар юм. Иймээс багш, бусад ажилтан тэгш хамран сургах орчин бүрдүүлэхэд шаардлагатай суурь үнэт зүйлс, цогц чадамж эзэмшүүлэх боловсрол, сургалтад хамрагдсан байх ёстой.
5. **Ялгаатай байдлыг үнэлж хүндэтгэх:** Суралцаж буй хамт олны бүх гишүүдэд адил тэгш хандаж хувь хүний онцлогийг үл хамааран хүн бүртэй хүндэтгэлтэй харьцах ёстой. Олон талт байдлыг хүндэтгэх нь зөвхөн хүлээн зөвшөөрөх үзэл баримтлалаар хязгаарлагдахгүйгээр харилцан хүндэтгэл, хамтын үнэт зүйлсийг бий болгох явдал юм. Суралцагч бүрийг хувь хүнийх нь хувьд хүлээн зөвшөөрч хүндэтгэдэг, боловсрол, сургалт нь суралцагч бүрийн тусгайлсан хэрэгцээ шаардлагад нийцсэн байх ёстой. Мөн аливаа хэлбэрийн ялгаварлан

гадуурхал, доромжлол, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ авдаг байх шаардлагатай.

- 6. Суралцах үйлийг дэмжсэн ээлтэй орчин:** Тэгш хамран сургах боловсролын орчин нь суралцагч бүр аюулгүй, дэмжлэгт, урамшуулсан байдлыг мэдэрдэг, өөрийгөө илэрхийлж чаддаг хүртээмжтэй орчин байх юм. Сургуулийн эерэг, тэгш хамруулсан соёлын үндсэн бүрэлдэхүүн хэсэг нь суралцагчид бөгөөд тэд соёлыг хөгжүүлэхэд шууд оролцоотой байна.
- 7. Үр дүнтэй шилжилт өөрчлөлт:** Бүх суралцагчид, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид сургуульд суралцаж төгссөний дараа мэргэжлийн болон дээд боловсрол улмаар хөдөлмөрийн зах зээлд шилжихэд дэмжлэг авдаг байна (насан туршийн хөгжилд нь анхаарсан).
- 8. Түншлэлийг хүлээн зөвшөөрөх:** Суралцахуйн орчин болон олон нийтийн өргөн хүрээний харилцаа нь тэгш хамарсан нийгэмд хүрэх зам гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Багш нарын холбоо, эцэг эхийн бүлгүүд, төрийн бус байгууллага, иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоо нь тэгш хамарсан сургалттай цэцэрлэг, сургуулийн загварыг дагасан тэгш хамруулсан нийгмийн хамт олныг бий болгоход чухал бөгөөд хүн бүр өөрийн хүлээх үүрэгтэй байна.
- 9. Хяналт-шинжилгээ:** Тэгш хамран сургах боловсролын ахиц дэвшилд тасралтгүй хяналт-шинжилгээ хийх үйл хэрэгт хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хэлний болон үндэстний цөөнх бүлгийн хүмүүс, дэмжлэг шаардлагатай нэн ялангуяа, нийгмийн эмзэг бүлгийн төлөөллийг оролцуулах ёстой. Хяналт-шинжилгээ, үнэлгээг албан ба албан бус байдлаар хийх бөгөөд энэ үйл ажиллагаанд бодлого, үйл ажиллагааны үр нөлөө шууд хүрдэг бүлгийг тогтмол оролцуулж байх хэрэгтэй.

### ● **Ерөнхий зөвлөмжийн бусад бүрэлдэхүүн**

Тэгш хамрагдан сурч боловсрох эрхийг аливаа ялгаварлан гадуурхлаас ангид, тэгш боломжийн үндсэн дээр хангах ёстой. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ерөнхий боловсролын тогтолцооны гадна үлдээхийг, тэр дундаа тэдний хөгжлийн бэрхшээлд тулгуурласан эсхүл бэрхшээлийн төрөл, байдлаас хамаарч тэгш хамрагдах боломжийг хязгаарласан аливаа хууль тогтоомж, зохицуулалтын холбогдох заалтыг хориглох шаардлагатай гэсэн үг. Улс орнуудын Засгийн газар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг



тусгаарлан сургахыг хориглох бөгөөд сургалтын хүртээмжтэй орчин, тохируулгат хэрэглэгдэхүүнээр тус тус хангах ёстой. Саадгүй нэвтрэх барилга байгууламжийн хүртээмжтэй байдлын үр шимийг хүн амын тодорхой бүлгүүд хүртдэг бөгөөд энэ нь үе шаттайгаар хэрэгжих цогц стандартад суурилсан байдаг. Сургалтын хэлбэр, арга зам нь хүртээмжтэй байх шаардлагатай бөгөөд сургалтыг хүртээмжтэй орчинд явуулах ёстой. Тохируулгат хэрэглэгдэхүүн нь хувь хүний хувьд хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нэмэлт дэмжлэг юм.

Боловсролын тогтолцоо нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүн бүрийн өвөрмөц давуу тал, авьяас чадварыг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх бөгөөд энэ нь хоорондоо харилцан уялдаа холбоо бүхий хүрэлцээтэй, хүртээмжтэй, хүлээн зөвшөөрөгдсөн болон уян хатан байх гэсэн дөрвөн шинжийг агуулсан байх ёстой. Чанартай, хүртээмжтэй, үнэ төлбөргүй бага боловсролыг заавал эзэмшүүлэх нь нэн тэргүүний үүрэг бөгөөд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын 24 дүгээр зүйлийг бүрэн биелүүлэхэд улс орнуудын Засгийн газар аль болох шуурхай, үр дүнтэй арга хэмжээ авах тодорхой, тасралтгүй үргэлжлүүлэх үүрэг хүлээж, хэрэгжүүлэх ёстой. Энэ нь боловсролын зэрэгцсэн хоёр тогтолцоотой байх явдлаас өөр<sup>15</sup> юм.

Тэгш хамран сургах боловсролын тогтолцоо нь хүүхдийн үзэл бодол, хувь хүний онцлог, гэр бүлийн бат бөх байдлыг хадгалах, хүүхдэд тавих анхаарал халамж, хүүхэд хамгаалал, аюулгүй болон аливаа эмзэг байдал, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх зэрэг эрхийг харгалзан үздэг байх шаардлагатай. Боловсролын тогтолцоонд сэргээх болон нөхөн сэргээх үйлчилгээг аль болох эрт үед нь үзүүлэх хэрэгтэй. Уг үйлчилгээ нь олон салбарын төлөөллөөс хийсэн суралцагчийн давуу талын үнэлгээнд тулгуурладаг байх ёстой. Түүнчлэн хувь хүний бие даасан байдлыг хангах, нэр төрийг нь дээдлэх, бие махбод, оюун санаа, нийгэм, мэргэжлийн бүрэн дүүрэн ур чадвартай байх, нийгмийн амьдралын бүхий л үйл хэрэгт тэгш хамрагдах, оролцоход дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн байна.

15 Өмнөхтэй ижил, 13 дахь нүүр, 39 дэх догол мөр

## ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН ХАРИЛЦАН УЯЛДАА БҮХИЙ 4 ШИНЖ ЧАНАР

*Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын Ерөнхий зөвлөмж 4*

**A****AVAILABILITY**

ХҮРЭЛЦЭЭТЭЙ  
БАЙХ

**A****AVAILABILITY**

ХҮРТЭЭМЖТЭЙ  
БАЙХ

**A****AVAILABILITY**

ХҮЛЭЭН  
ЗӨВШӨӨРӨГДСӨН  
БАЙХ

**A****AVAILABILITY**

УЯН ХАТАН  
БАЙХ

Боловсролын тогтолцоо нь хувь хүн бүрийн өвөрмөц давуу тал, авьяас чадварыг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх бөгөөд дээрх харилцан уялдаатай дөрвөн шинж чанарыг агуулсан байх ёстой.

## ● Тэгш хамран сургах боловсролын үр өгөөж

Тэгш хамран сургах боловсролын үр өгөөж маш их. Тэгш хамран сургах боловсролын үр өгөөжийг суралцагч, багш нараас эхлээд бүхий л хүн ам төдийгүй боловсролын тогтолцоо ч өөрөө хүртдэг. Тэгш хамран сургах боловсролыг гол төлөв хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын талаарх ойлголт хэмээн явцуу хүрээнд хязгаарлагдмал байдлаар авч үздэг ч өргөн хүрээнд тэгш хамран сургах боловсрол бол БҮХ хүүхдэд буюу хүүхэд бүрд олгох боловсрол билээ!

Тэгш хамран сургах боловсролын тогтолцоог хөгжүүлэх (ердийн/тусгай боловсролын зэрэгцсэн тогтолцоог татан буулгах) нь нийгмийн эмзэг бүлгийн хүүхдүүд бусадтай адил тэгш байдлаар боловсрол эзэмшиж, тэгш боломжоор хангагдах явдлыг баталгаажуулна. Энэ нь урт хугацаандаа дотоодын нийт бүтээгдэхүүний алдагдлыг ойролцоогоор 5-7 хувиар (үр дүн, орлогын алдагдал), мөн нийгмийн халамжид тулгарах дарамтыг ч бууруулдаг байна. Тэгш хамран сургах тогтолцоог бүрдүүлснээр боловсролд зарцуулах зардал буурна. Харин тусгаарласан байгууламж (тусгай сургууль)-тай нөхцөлд 7-9 дахин илүү зардал зарцуулдаг бөгөөд тусгай боловсролын нэг хүүхдэд ногдох зардал ердийн сургуулийнхаас дунджаар 2.5 дахин их байна.

Тэгш хамруулалтын нийгэмд үзүүлэх үр нөлөөг тоочиж баршгүй. Гэсэн хэдий ч өөр өөр онцлог байдлыг агуулсан орчинд боловсрол эзэмшсэн хүүхдүүд илүү эерэг харилцаатай болж, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх зан үйл, хэм хэмжээний талаар илүү сайн ойлгож, нийгэм-сэтгэл зүйн цогц чадамж өндөр болдог. Түүнчлэн (бүх хүний хувьд) насан туршдаа бие даан амьдрахад нь шаардлагатай нийгэм-сэтгэл зүйн гол ур чадварыг зөвхөн тэгш хамруулсан орчинд л эзэмших боломжтой.

Тэгш хамруулсан орчинд ажилладаг багш нар хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг хамруулан бүх суралцагчдад өндөр хүлээлт тавьдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон бусад эмзэг бүлгийн хүүхдүүдийг тэгш хамруулснаар багшийн мэдлэг, ур чадвар сайжирч бүх суралцагчийн сурах үйл (хүлээлт ба үр дүн)-д эергээр нөлөөлдөг.

Нийгэмд тогтсон уламжлалт зарим хандлагаас ялгаатай нь тэгш хамруулсан ердийн ангид хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах нь бусад суралцагчдын хичээлдээ зарцуулах цагт сэргээр нөлөөлдөггүй. Харин ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд суралцахад нь зааварлан тусалдаг хөгжлийн бэрхшээлгүй суралцагч идэвхгүй суралцах үед олж авах боломжгүй гүнзгий мэдлэг, ур чадварыг эзэмшдэг. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй найзалж нөхөрлөдөг хүүхдүүд ихэнхдээ ийм туршлага хуримтлуулаагүй бол

мэдэхгүй байсан ухагдахууны талаар ойлголт мэдлэгтэй болж илүү хүсэл эрмэлзэлтэй болсон байдагтай холбоотой байх талтай юм.

Эцэст нь тэгш хамруулсан сургуульд суралцсан хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид амжилттай суралцсан үр дүн (ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтээр хэмжихэд)-тэй байх хандлагатай бол тусгаарлагдсан орчинд суралцсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурлагын амжилттай харьцуулахад тэдэнд үзүүлэх үр өгөөж сайн байна. Тэгш хамруулсан орчинд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тусгай сургуульд сурч байгаа хүүхдүүдтэй харьцуулахад илүү уян хатан сургалтын хөтөлбөрөөр суралцаж, сурлагын амжилтын хувьд өндөр хүлээлттэй байдаг. Тэд тэгш хамруулсан үйл явдлыг илүү ихээр эрэлхийлж, нийтийн дунд илүү цаг өнгөрөөх дуртай болдог байна.

### ● Хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ

Тэгш хамран сургах боловсролын тогтолцоо бүрдүүлэх ажлыг бодитой болгоход дараах долоон чиглэлээр арга хэмжээ<sup>16</sup> авч хэрэгжүүлэх шаардлагатай:

Нэгдүгээрт, бүх суралцагчдад боловсрол олгох үүргийг Боловсролын яамд хариуцах тул бүтэц, тогтолцоог бэхжүүлэх хэрэгтэй. Иймээс Засгийн газар бүх түвшинд үүрэг хүлээж, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах, түншлэлийг бэхжүүлэх шаардлагатай. Тэгш хамруулалт бол хүн бүрийн үйл хэрэг!

Хоёрдугаарт, хууль тогтоомж, бодлогод өөрчлөлт оруулахдаа хүний эрхийн стандарттай нийцсэн байх, тэдний үзэл бодлоо илэрхийлэх явдлыг тусгахыг баталгаажуулах ёстой. Засгийн газар нь тэгш хамрагдан сурч боловсрох эрхийн тодорхойлолтыг гаргаж батлахын зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй суралцагч боловсролын үйлчилгээний гадна үлдэх явдлыг таслан зогсоох, тусгай боловсролын байгууллагыг татан буулгах чиглэлээр үүрэг амлалт өгөх ёстой. Боловсролын хүртээмж, зохистой дэмжлэгээр хангах явдлыг баталгаажуулах, тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангагдах хэрэгцээ шаардлагыг хүлээн зөвшөөрөх ёстой. Боловсролын чанарын цогц стандарт мөрдөх шаардлагатай бөгөөд энэ нь эрт илрүүлэг болон дэмжлэгийн

16 НҮБ-ын Хүүхдийн Сан (2017) Тэгш хамран сургах боловсрол – Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг тухай конвенцын 24 дүгээр зүйлийг ойлгох нь. НҮБ-ын Хүүхдийн Сан. [https://www.unicef.org/eca/sites/unicef.org.eca/files/IE\\_summary\\_accessible\\_220917\\_0.pdf](https://www.unicef.org/eca/sites/unicef.org.eca/files/IE_summary_accessible_220917_0.pdf) холбооцоор 2022 оны 7 дугаар сарын 5-нд мэдээлэл авсан (UNICEF (2017) Inclusive Education – Understanding Article 24 of the Convention on the Rights of Persons with Disabilities. UNICEF. [https://www.unicef.org/eca/sites/unicef.org.eca/files/IE\\_summary\\_accessible\\_220917\\_0.pdf](https://www.unicef.org/eca/sites/unicef.org.eca/files/IE_summary_accessible_220917_0.pdf))

хүрэнээс эхлэх ёстой. Бүх суралцагчийг боловсролын үйлчилгээнд хамруулах ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх үүргээ орон нутгийн удирдлага биелүүлэхдээ гол оролцогч талуудтай хамтын ажиллагааны түншлэл бий болгох шаардлагатай.

Гуравдугаарт, тэгш хамран сургах боловсрол нь боловсролын салбарын үндэсний төлөвлөгөөний гол тулгуур байх ёстой. Хэрэгжилтийн явцын төлөвлөлт нь цаг хугацааны хүрээ, хэмжигдэхүйц зорилттой уялдсан байхаас гадна хяналт хийх, нэмэлт, өөрчлөлт оруулах боломжтой байна. Боловсролын салбарын төлөвлөгөө нь олон эх үүсвэрээс цуглуулсан мэдээлэл, олон нийтийн хэлэлцүүлэг болон улс орны нөхцөл байдал (суурь судалгаа)-ын судалгаа, дүн шинжилгээнд заавал суурилах ёстой.

Дөрөвдүгээрт, хүний болон санхүүгийн нөөцийг хангалттай байлгах талаар Засгийн газар амлалт өгөх ёстой. Энэ амлалтыг хэрэгжүүлэхэд бүх талын хүчин чармайлт шаардана. Хангалттай нөөц бүрдүүлэхэд нэг талаас, хувийн хэвшилтэй хамтран ажиллах, тэгш хамруулалтыг урамшуулах санхүүжилтийн загварыг багтаасан засаглал болон санхүүжилтийн тогтолцоонд шинэчлэл хийх, нөгөө талаас, тусгаарласан орчноос тэгш хамруулсан орчин бий болгоход зориулан нөөцөө шилжүүлж, улмаар тэгш хамран сургах боловсролд зарцуулах нийт төсвийг нэмэгдүүлэх ёстой. Суурь санхүүжилт буюу эхлэлийн үед санхүүжилт шаардагдах зарим хөрөнгө оруулалт (жишээ нь: сургалтын хүртээмжтэй орчин, нөөц бүрдүүлэх; туслах технологиор хангах; тэгш хамран сургах багшийн сургалтад хөрөнгө оруулалт хийх; гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалтай холбоотой асуудлыг шийдвэрлэх) урт хугацааны үр нөлөө үзүүлдэг. Тэгш хамран сургах боловсрол бол ухаалаг хөрөнгө оруулалт юм!

Тэгш хамран сургах боловсролын тогтолцоонд хэрэгжүүлэх дараагийн арга хэмжээ нь багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, багшид дэмжлэг үзүүлэх асуудал юм. Тэгш хамран сургах боловсрол нь бүх түвшний багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийн нэг хэсэг байх ёстой. Багш бэлтгэх хөтөлбөрийн зарим агуулгад хүний олон талт ялгаатай байдал ба хүний эрх, тэгш хамран сургах арга зүй, харилцаа, тохируулга бүхий заах арга зүй, ялгаатай байдлаар заах арга зүйг багтаасан байх ёстой. Багш нарт үзүүлэх дэмжлэг нь сургууль хоорондын түншлэл бий болгох (нөөцийг нэмэгдүүлэх), хичээлийг багаар хамтран заах, үнэлгээг багш нар хамтран хийх, эцэг эхчүүдийг татан оролцуулах, орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах зэргээс бүрдэж болно.

Зургаа дахь асуудал бол суралцагчийн үнэлгээ. Энэ нь суралцахуйн түгээмэл загварын зарчимд суурилсан арга бүхий сургах болон сурах үйлийн

хэрэгжилт юм. Иймд сургах, сурах болон үнэлэх үйл нь суралцагчдад юу зааж, тэд юу сурч мэдсэнээ үнэлүүлдэг үр дүнтэй мөчлөг болно. Үнэлгээ нь өрсөлдөөнт үйл явц гэхээс илүү хувь суралцагчийн суралцахуйн зорилтын хэрэгжилтийг илэрхийлэх бөгөөд шийтгэлийн шинж чанаргүй байх ба багш нарын хувьд тэдний практик үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх хэрэгслийн нэг юм.

Эцэст нь тэгш хамран сургах боловсролын тогтолцоо нь боловсролын салбарын төлөвлөгөөнд тодорхойлсон зорилго, хэрэгжилтийн төлөвлөсөн үе шаттай харьцуулан ахиц дэвшлийг хэмжих үүрэг хариуцлага, хяналт-шинжилгээний хүрээг агуулдаг. Мөн суралцагчдад тэдний эрх, эрх нь зөрчигдсөн тохиолдолд гомдол гаргах хүчин төгөлдөр үйлчилж буй механизмын талаар мэдээлэл өгдөг байх шаардлагатай бөгөөд суралцагчид өөрсдийн эрх зөрчигдсөн тухай аюулгүй, ил тод, үр дүнтэй байдлаар илэрхийлэх боломжтой байх ёстой. Суралцагчид, эцэг эх, асран хамгаалагчид, багш нар болон боловсролын бусад мэргэжилтнүүд хүүхдийн эрхийн талаар бүрэн мэдлэгтэй байх шаардлагатай.

## ● МОНГОЛ УЛС ДАХЬ ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ БОДЛОГЫН ХУРААНГУЙ

ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГОД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ ЗӨВЛӨХИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Олон улсын гэрээ хэлэлцээрт хүний сурч боловсрох эрхийн асуудлыг 1948 оноос хойш онцлон тусгасаар ирсэн байдаг. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр дэлхий дахины бодлого, хууль тогтоомж нь тэгш хамруулсан үйл ажиллагаанд чиглэсэн шинжтэй болсоор байгаа ч 2018 оны байдлаар 258 сая орчим хүүхэд, залуус сургуулийн гадна байсаар байна<sup>1</sup>.

Монгол Улсын Үндсэн хууль (1992), Боловсролын тухай хууль (2002)-д алагчлалаас ангид сурч боловсрох эрхийг тунхаглан баталгаажуулжээ. Боловсролын салбарын бодлогод хөгжлийн бэрхшээлтэй, хөдөө орон нутгийн болон нийгмийн эмзэг бүлгийн иргэд зэрэг бүх нийтэд хүртээмжтэй, тэгш хамран сургах боловсрол эзэмших нөхцөлийг боловсролын бүх түвшинд, нутаг дэвсгэрийн бүх нэгжид бүрдүүлэх зорилгыг тусгажээ. Боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байх бөгөөд энэ нь сургуулийн өмнөх боловсрол (4 жил), заавал эзэмших бага (5 жил) болон суурь боловсрол (4 жил), бүрэн дунд боловсрол (3 жил), мэргэжлийн боловсрол, сургалт, дээд боловсролоос бүрддэг байна. Бүрэн дунд боловсролоос бусад бүх түвшинд хамран сургалтын цэвэр жин өндөр байна (2019-2020 оны хичээлийн жилийн байдлаар 93.3 хувь<sup>2</sup>, 86.5 хувь<sup>3</sup>).

### ● Сурч боловсрох эрх Монгол Улсад

Хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний/хэлний цөөнх бүлгийн, малчин өрхийн хүүхдүүд зэрэг бусад цөөнхийн бүлгийн хүүхдүүд гээд Монгол Улсын бүх иргэдийн боловсролыг дэмжсэн нэлээдгүй хууль тогтоомж, бодлогын баримт бичиг батлагдан хэрэгжиж байна. Тэдгээрт ерөнхий боловсролыг төлбөргүй заавал эзэмших болон насан туршдаа суралцах явдлыг ч тусгажээ.

1 <http://uis.unesco.org/en/topic/out-school-children-and-youth>

2 УСХ. 2019. Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2018, Түүвэр судалгааны үр дүнгийн тайлан. Улаанбаатар, Монгол Улс: Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо. (SISS2018-MICS6 SFR\_English.pdf (mics-surveys-prod.s3.amazonaws.com)) Үндэсний статистикийн хороо, 2019.

3 өмнөхтэй ижил

Боловсролын тухай хууль (2002)-д “хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн бие эрхтэн, хөгжлийн онцлогийг хүндэтгэн үзэж, хөгжлийн бэрхшээлтэй суралцагч бусдын адил тэгш байх нөхцөлийг бүрдүүлэх”-ээр заасан. Хүүхдэд ээлтэй сургуулийг дэмжих бодлого (2004), Боловсролын салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө (2006-2015)-нд хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт, эрт оролцооны арга хэмжээ авах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд суралцахуйн дэмжлэг үзүүлэх (ердийн эсхүл тусгай цэцэрлэгт хамруулах, шаардлагатай дэмжлэгт үйлчилгээний дор ерөнхий боловсролын ердийн сургуульд суралцуулах) болон мэргэжилтнүүдэд дэмжлэг үзүүлэх талаар тодорхой заажээ. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль (2008) болон сүүлийн үед гарсан хууль тогтоомж, шийдвэрийн дагуу хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн цэцэрлэгт хамруулах боломжтой. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулах талаар төрөл бүрийн арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа ч хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг тусгай хоёр цэцэрлэгээр л үйлчилгээ үзүүлж байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар (2011) хөвгүүд, охидыг боловсролын үйлчилгээгээр адил тэгш хангах явдлыг дахин баталгаажуулсан байна. Харин Хүүхдийн эрхийн тухай хууль (2016)-д “хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох”<sup>4</sup> болон тэдний үзэл бодолд хүндэтгэлтэй хандах зэрэг суурь эрхийг баталгаажуулж, хүүхдийн төрөлх хэл, ёс заншил, түүх соёлын уламжлалыг өвлөн эзэмших эрхтэй холбогдсон харилцааг тодорхой зохицуулжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016)-д хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрхийг баталгаажуулж, тэдний авьяас билэг, бүтээлч чанар, оюуны болон бие бялдрын чадварыг хөгжүүлэх, бүх шатны боловсролын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ) боловсруулж хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээг төрөөс авч хэрэгжүүлэхээр заасан байна. Харин ердийн сургуулиуд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцсэн анги, танхим болон тусгай материалтай байх<sup>5</sup> асуудлыг үүрэг болгон хүлээлгэсэн нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцод нэгдэн орсон улс орнуудын хэлэлцэн тохиролцсон “... тусгай болон ердийн сургуулийн тогтолцоо зэрэгцэн орших ёсгүй” гэсэн үзэл баримтлалд нийцэхгүй байна.

4 Монгол Улсын Засгийн газар (2016) Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хууль, 4 дүгээр бүлэг

5 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйл - 14.3.2 дахь заалт



## ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

---



Нэг, нэгнийхээ талаар мэдэж авч, хамтдаа эв найртай байхад нь

---



Илүү сайн боловсрол эзэмшихэд нь

---



Бие даан илүү ихийг хийж, илүү олон ур чадварт суралцахад нь

---



Бусадтай нэгдэх болон нийгмийн идэвхтэй нэгэн гишүүн байхад нь

---



Цаашид ажил хөдөлмөр эрхэлж, ахуй амьдралаа сайжруулахад нь

---



Ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч хүн бүр үнэ цэнтэй, чадамжтай хэмээн хүндлэгдэхэд нь

---

Засгийн газрын 2016 оны 136 дугаар тогтоолоор хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хөгжлийн бэрхшээлийг илрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд тэгш оролцохыг дэмжсэн үйл ажиллагааг салбар дундын зохицуулалтаар хангах орон тооны бус зөвлөлийг байгуулж, ажиллах журмыг баталжээ. Зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд ахлах бөгөөд яамд, аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалахад чиглэсэн хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий дэд болон салбар зөвлөлтэй байхаар заасан.

Хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилсан ГСТ, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийн хөгжлийн ахиц, өөрчлөлтийг явцын үнэлгээгээр үнэлэх бөгөөд шалгуурыг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн болон үнэлгээний байгууллага хамтран боловсруулахаар заасан байна. ГСТ-ний зорилго, зорилтын ахиц, өөрчлөлтийг явцын үнэлгээгээр үнэлэх бөгөөд суралцагч боловсролын дараагийн түвшинд шилжин суралцах эсхүл төгсөхөд явцын үнэлгээнд тулгуурлан ахиц амжилтыг үнэлэхээр тусгажээ. Гэвч сургуулийн түвшинд ГСТ-г зорилгод нийцсэн байдлаар боловсруулах чадавх сул байна. Багш нар, сургуулийн захирал болон тэгш хамран сургах боловсролын дэмжлэгийн баг нь ГСТ боловсруулах үүрэг хүлээдэг. Харин ГСТ-нд тусгах асуудлын талаарх заавар, зөвлөмжийг салбар комиссын шийдвэрээс хүлээдэг боловч салбар комиссоос зөвхөн хүүхдийн эмгэг (эмнэлгийн оношилгоо) болон тухайн хүүхэд цэцэрлэг, сургуульд сурч болох эсэхийг заасан мэдээллээр хангадаг байна. Салбар комисс нь сургах/сурах үйл ажиллагаа эсхүл тохирох хэрэглэгдэхүүн буюу сургалтын орчин бүрдүүлэхэд хамаарах зөвлөмжөөр хангадаггүй байна.

Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль (2018)-д “Ерөнхий боловсролын сургуулийн 44-өөс дээш хүүхэдтэй нэг, хоёрдугаар ангид туслах багш” ажиллуулахаар заажээ. Мөн ердийн хэв шинж бүхий цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшид үндсэн цалингийн 10 хувьтай тэнцэх нэмэгдэл хөлс олгохоор зохицуулсан байна. Угурамшууллыг хөгжлийн бэрхшээлтэй нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаас тооцон олгох бөгөөд санхүүжилт нь хөгжлийн бэрхшээлгүй нэг хүүхдэд ногдох санхүүжилтээс 3 дахин их байхаар тогтоожээ<sup>6</sup>. Гэвч энэ зохицуулалтын хэрэгжилт бодит байдалд маш хязгаарлагдмал байна. Ерөнхийдөө багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэх

6 Бор, Б. (2021). Боловсролын өртөг зардал, санхүүжилтийн үндэсний кэйс судалгаа: Монгол Улс. Нийтлэгдээгүй. (Bor, B. (2021). National Case Study on Education Costing and Financing - Mongolia. Unpublished)

## ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛ БОЛ:

---



Аливаа ялгаатай байдлаас үл хамааран бүх хүмүүс хамтдаа суралцах явдал юм.

---



Цэцэрлэг, сургууль, коллеж, их сургуульд бүгд нэг анги танхимд хамтдаа хичээллэхийг хэлнэ.

---



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бусдаас тусгаарлан тусгай цэцэрлэг, сургуульд эсвэл өөр ангид сургана гэсэн үг биш юм.

---



Бүх суралцагчдад адил тэгш хандах зарчим юм.

---



Сурч боловсрох эрхээ эдлэхэд тулгарч буй саадыг арилгах үйл явцын үр дүн юм.

---



Хүний үндсэн эрх бөгөөд бусад эрхийг бодит болгох арга зам юм.

---

шаардлагатай эсэх, ямар төрлийн дэмжлэгийг хэзээ, хаана үзүүлэх талаар эргэлзсэн байдалтай байна. Одоо мөрдөж байгаа сургалтын хөтөлбөр уян хатан бус, академик мэдлэг эзэмшүүлэхэд чиглэсэн, хэрэглээний ур чадвар олгох агуулга багатай. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих хэрэгсэл, туслах технологи бүхий орчноор хангасан ч багш нар, эцэг эхчүүд хүүхдийнхээ сурлагын гүйцэтгэлд анхаарсан хандлага хэвээр байна. Санхүүжилт хангалттай тохиолдолд туслах технологи, хэрэгслийг бодит хэрэгцээнд тулгуурлан худалдан авалт хийдэггүй бөгөөд худалдан авсан хэрэгслүүд нь тухайн сургууль/ангийн хэрэгцээнд нийцдэггүй байна.

Засгийн газрын 2020 оны 235 дугаар тогтоолоор тэгш хамран сургах боловсролтой холбогдсон арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны яаманд даалгажээ. Тогтоолд тэгш хамруулсан үйлчилгээг бий болгох талаар холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулах, багш бэлтгэх, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын чанарыг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох орчин нөхцөлийг сайжруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг заасан байна. Энэ тогтоол нь тэгш хамран сургах боловсролыг өргөжүүлэхийг явцуу утгаар буюу зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын хүртээмжид чиглэсэн арга хэмжээний нэгэн жишээ. Тогтоол нь интеграцчилал (хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулах)-ыг тэгш хамран сургах (хүртээмж, оролцоо, амжилт)-тай дүйцэхээр авч үзсэн бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг одоогийн тогтолцооны хүрээнд тусгай цэцэрлэг, сургуульд тусгаарлан сургаж байгаа эсхүл ердийн цэцэрлэг, сургуулийн орчинд тусгай анги, бүлэгт тусад нь интеграцчилан сургаж буй өнөөгийн практикийг улам бэхжүүлэх магадлалтай юм. Тэгш хамран сургах боловсрол ба тусгай боловсрол гэсэн нэр томъёог адил утгаар хэрэглэх болон тэгш хамран сургах боловсролыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай ба ердийн сургууль/анги танхимд эзэмших боловсрол хэмээн тодорхойлох явдал түгээмэл байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/220, А/475, А/812 дугаар хамтарсан тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал”-ыг баталж, хөгжлийн хоцрогдол болон бэрхшээлтэй хүүхдүүдэд үзүүлэх дэмжлэгийн салбар дундын зохицуулалтыг тодорхойлжээ. Аргачлал нь “... хүүхдийн өөртөө итгэх итгэлийг хөгжүүлж, бусадтай харилцах, хамтран ажиллах, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцоход дэмжлэг үзүүлэх” (1 дэх тал) зорилготой бөгөөд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-ийн 37.1-д заасан шалгуурын дагуу 37.2.1-д заасан комиссын хурлаар хөгжлийн бэрхшээлтэй болох нь тогтоогдсон” (1 дэх тал) хүүхдэд хамаарна гэсэн байна.

### ● Тэгш хамрагдан сурч боловсрох эрх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороо – Ерөнхий зөвлөмж 4 (2016) Тэгш хамрагдан сурч боловсрох эрхийн тухай (24 дүгээр зүйл)-д зааснаар тэгш хамран сургах боловсрол нь бүх суралцагчдад чанартай боловсрол олгоход чухал юм. Бүх түвшинд (сургуулийн өмнөх боловсрол, бага, дунд, дээд боловсрол, мэргэжлийн сургалт, насан туршийн суралцахуй, хичээлээс гадуурх болон олон нийтийн үйл ажиллагаа) бүх суралцагч түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхлаас ангид, бусадтай адил тэгш байдлын үндсэн дээр боловсрол эзэмших эрх хэрэгжих ёстой. Тэгш хамран сургах боловсрол нь соёл, бодлого болон практик үйл ажиллагаанд хийх өөрчлөлт, саад бэрхшээлийг арилгах амлалт, бүх суралцагчдад хүрч ажиллах боловсролын тогтолцооны чадавхыг бэхжүүлэх үйл хэрэг билээ. Тэгш хамран сургах боловсрол нь бүх суралцагчийг ялгаварлан гадуурхалгүйгээр тэдний бүрэн дүүрэн үр дүнтэй оролцоо, хамрагдалт, хичээлийн ирц болон амжилтад гол анхаарлаа хандуулдаг. Энэ нь сургалтын агуулга, арга зүй, арга хандлага, бүтэц болон стратегид хийх өөрчлөлт, шинэчлэлийг тодорхойлсон тогтолцооны шинэчлэлийн үйл явц юм. Тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэхэд оролцогч улс орнууд санхүүгийн болон хүний нөөцийг хангалттай зориулах шаардлагатай.

Тэгш хамран сургах боловсрол нь дараах есөн үндсэн шинж чанарыг агуулдаг:

1. **“Тогтолцоо бүхэлдээ” арга хандлага:** тэгш хамран сургах боловсролыг дэмжихэд бүхий л нөөцийг зориулах;
2. **“Боловсролын орчныг иж бүрнээр нь”** буюу соёл, бодлого, практик үйл ажиллагааг бэхжүүлэх;
3. **“Хувь хүнийг цогцоор нь” авч үзсэн арга хандлага:** хүн бүр суралцах чадавхтайг хүлээн зөвшөөрч, бүх суралцагчдын хувьд өндөр хүлээлт тавих. Тэгш хамран сургах боловсрол нь харилцан адилгүй давуу тал, өөр хоорондоо ялгаатай шаардлага, суралцахуйн хэв маягт нийцсэн уян хатан сургалтын хөтөлбөр, сургах болон сурах арга зүйгээр хангадаг. Хичээлийг төлөвлөхдөө сургалтын агуулгаас илүү суралцагчдын чадавх, хүсэл эрмэлзэлд анхаарал хандуулдаг;
4. **Багш нарт дэмжлэг үзүүлэх:** Бүх багш, бусад ажилтан тэгш хамруулсан сургалтын орчныг бүрдүүлэхэд шаардлагатай суурь үнэт зүйлс, цогц чадамжийг олгох боловсрол, сургалтад хамрагдсан байх;
5. **Ялгаатай байдлыг үнэлж, хүндэтгэх:** Суралцаж буй хамт олны бүх гишүүдэд адил тэгш хандаж, тэдний олон янз байдлыг хүндэтгэх;

6. **Суралцах үйлийг дэмжсэн ээлтэй орчин:** Тэгш хамран сургах боловсролын орчин нь суралцагч бүр аюулгүй, дэмжлэгт, урамшуулсан байдлыг мэдэрдэг, өөрийгөө илэрхийлж чаддаг хүртээмжтэй орчин байх;
7. **Үр дүнтэй шилжилт:** Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад ерөнхий боловсролын сургууль төгсөөд мэргэжлийн болон их, дээд сургуульд дэвшин суралцаж улмаар ажил хөдөлмөрийн талбарт үр дүнтэйгээр шилжихэд нь шаардлагатай дэмжлэг үзүүлэх (насан туршийн хөгжилд нь анхаарах);
8. **Түншлэлийг хүлээн зөвшөөрөх:** Суралцахуйн орчин болон иргэд олон нийтийн хоорондын харилцааг тэгш хамруулсан нийгэм рүү хөтлөх арга зам гэдгийг хүлээн зөвшөөрөх;
9. **Хяналт-шинжилгээ:** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулах.

Тэгш хамрагдан сурч боловсрох эрхийг ялгаварлан гадуурхалтаас ангид, тэгш боломжийг хангах замаар баталгаажуулна. Ялгаварлан гадуурхалтаас ангид байх гэдгийг тусгаарлагдахгүй байх, хүртээмжтэй сурах орчин, тохируулгат хэрэглэгдэхүүнээр заавал хангагдах явдал гэж ойлгоно. Дэд бүтцийн хүртээмжтэй байдал нь нийгмийн тодорхой бүлгийн хүмүүст ач тустай байдаг бөгөөд үе шаттай хэрэгжих багц стандартад суурилдаг. Тохируулгат орчин, хэрэглэгдэхүүн нь хувь хүнд хамаарах бөгөөд хүртээмжтэй байдлыг хангах үүрэгт нэмэлт дэмжлэг болдог. Сургалтын хэлбэр, арга нь хүртээмжтэй байх ёстой бөгөөд сургалтыг хүртээмжтэй [буюу дэд бүтцийн хувьд саадгүй] орчинд зохион байгуулах шаардлагатай. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ерөнхий боловсролын тогтолцооны гадна үлдээх тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй байдал эсхүл хөгжлийн бэрхшээлийн төрөл, түвшнээс нь хамаарч тэдний оролцоог хязгаарласан хууль тогтоомж, зохицуулалтын холбогдох заалтыг ч хориглох ёстой. Боловсролын тогтолцоо нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүн бүрийн өвөрмөц давуу тал, авьяас чадварт тулгуурлан төрөл бүрийн боломжийг бий болгоход дэмжлэг үзүүлэх ёстой.

Боловсролын тогтолцоо нь өөр хоорондоо харилцан уялдаа бүхий хүрэлцээтэй, хүртээмжтэй, хүлээн зөвшөөрөгдсөн болон уян хатан байх гэсэн дөрвөн шинж чанарыг агуулсан байх ёстой. Чанартай, хүртээмжтэй, үнэ төлбөргүй бага боловсролыг заавал эзэмшүүлэх нь нэн тэргүүний үүрэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын 24 дүгээр зүйлийг бүрэн хэрэгжүүллийн тулд улс орнуудын Засгийн газар аль болох шуурхай, үр дүнтэй арга хэмжээ авах тодорхой үүргийг тасралтгүй хэрэгжүүлэх ёстой. Энэ нь боловсролын зэрэгцсэн хоёр тогтолцоотой байх явдлаас өөр юм.

## ● Тэгш хамрагдан сурч боловсрох эрх Монгол Улсад

### “Тогтолцоо бүхэлдээ” арга хандлага

Тэгш хамран сургах боловсрол нь Монгол Улсын хувьд харьцангуй шинэ ойлголт юм. Зөвлөлт Холбоот Улсын үеийн “согог судлал” (дефектологи)-ын уламжлал хүчтэй хэвээр байсаар байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тусгай сургуулиар дамжуулан боловсролын тогтолцоонд хамруулахад анхаарал хандуулсаар байгаа тул тэгш хамран сургах боловсролын жишээ одоогоор цөөн байна.

Боловсролын тогтолцоог БҮХ хүүхдэд хүрч дэмжлэг үзүүлэхэд чиглүүлэн бэхжүүлэх хэрэгцээ байгаа талаар сайн мэдэж буй ч бодлогын орчин хангалттай түвшинд хөгжөөгүй байна. Тогтолцоог цогцоор нь хөгжүүлэхээс илүүтэйгээр тодорхой асуудлуудыг салангид байдлаар шийдэж ирсэн нь хоорондоо уялдаа холбоогүй хууль тогтоомжийн олон нэмэлт, өөрчлөлтөөс (Бага, дунд боловсролын тухай хууль 2002 онд батлагдсанаас хойш нийт 13 удаа нэмэлт, өөрчлөлт орсон) үүдэлтэй байж болох талтай юм. Энэхүү шалтгааны улмаас “тэгш хамран сургах боловсрол”-ын талаар гаргасан хүчин чармайлт нь ихэнхдээ одоогийн (интеграцчилсан) тогтолцооны хүрээнд л хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхцөл байдлыг сайжруулахад чиглэжээ. Харин суралцагчдын олон янз байдалд нийцүүлэн арга хэмжээ авах байдлаар тогтолцоог цогцоор нь өөрчлөх хэрэгцээ шаардлага бодлогын өөрчлөлтөд хараахан тусгагдаагүй байна.

### “Боловсролын орчныг иж бүрнээр нь” авч үзэх

Өнөөг хүртэл хийгдсэн эрх зүйн шинэчлэл нь Монгол Улсын боловсролын эрх зүйн орчныг Тогтвортой хөгжлийн зорилго 4-тэй уялдуулж, улс орны нөхцөл байдалд тохируулан нэмэлт, өөрчлөлт оруулахад чиглэж иржээ. Гэвч Монгол Улсад тэгш хамран сургах боловсролын соёл хараахан төлөвшөөгүй байна. Хүүхдийг чадвар, үндэс угсаа, эх хэл, газарзүйн байршил, хүйс, нийгэм-эдийн засгийн байдлаар нь ил эсхүл далд хэлбэрээр ангилж, бага наснаас нь эхлэн суралцах ямар чадамжтайг болон тэдний хувьд сургалтын тохирох орчин юу байхыг таамаглан тодорхойлдог байна. Хос хэлний боловсролын асуудлыг бодлого боловсруулах мэргэжилтнүүдийн хувьд эмзэг сэдэв гэж хардаг бөгөөд хөгжлийн бэрхшээлийг орчны саадтай шууд холбон авч үзэж байгаа нь сүүлийн үеийн ойлголтоос илүүтэйгээр хөдлөшгүй төлөв байдал гэж харсан хэвээр байна. Бодлого нь суралцагч бүрийг тэгш хамруулах орчин нөхцөлийг бүрдүүлэхээс илүүтэйгээр тодорхой бүлгийн хүүхдүүдийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэх хандлагатай байна.

### “Хувь хүнийг цогцоор нь” авч үзэх

Хүүхдүүдийг тодорхой онцлог шинжээр нь ангилсны улмаас тодорхой бүлгийн хүүхдийн хувьд суралцах чадварыг нь ялгаатай байдлаар тодорхойлоход хүргэж байна. Нүдэнд ил харагдах бэрхшээлтэй хүүхдүүд ялангуяа хүнд эсхүл хавсарсан бэрхшээлтэй хүүхдүүдийг ердийн сургуульд суралцахыг ихэнх тохиолдолд дэмждэггүй бөгөөд тэднийг сургуульд хамруулах тохиолдолд судлах агуулгыг нь багасгасан сургалтын хөтөлбөрөөр хичээллэдэг тусгай зургаан сургуулийн аль нэгэнд нь суралцуулж байна. Мөн угсаатны болон хэлний цөөнхийн бүлгийн хүүхдүүд бага ангидаа эх хэлээрээ суралцдаг бөгөөд тэд монгол хэлийг харилцааны хэрэгслээр бус зөвхөн академик хичээлийн хувьд судалдаг нь бусадтай адил их, дээд сургуульд суралцах, хөдөлмөр эрхлэх боломжид нь сөргөөр нөлөөлж байна. Сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт нь үнэлгээний бодлого өөрчлөгдөхөд нөлөөлсөн. Гэвч алслагдсан хөдөө орон нутагт амьдарч байгаа угсаатны цөөнх, малчдын болон дотуур байранд амьдарч байгаа хүүхдүүдийн боловсролын чанар, мэдлэг, ур чадвар төв суурин газарт амьдарч байгаа хүүхдүүдтэй харьцуулахад доогуур хэвээр байна<sup>7</sup>.

Сурах бичиг хэвлэн, түгээх найдвартай тогтолцоо бүрдээгүй бөгөөд хувийн хэвшлийн оролцоотой байгаа байдал нь хөдөө орон нутагт амьдарч байгаа хүүхдийн сурах бичгийн хангамжид нөлөөлж байна. Сурах бичиг хангамжийн тогтолцоо найдваргүйн улмаас сурах бичгийг хүртээмжтэй [хэрэглэхэд хялбар, дөхөм] хэлбэрээр түгээх боломж хомс юм. Зарим сурах бичгийг хөгжлийн бэрхшээлийн төрөлд зориулсан байдлаар боловсруулах арга хэмжээг бага ангийн түвшинд авч хэрэгжүүлсэн ч тоо хэмжээ, чанарын хувьд хангалттай бус байна. Дэд бүтцийн хүртээмжтэй байдал ихэнх цэцэрлэг, сургуульд шийдэгдээгүй бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг Насан туршийн боловсролын төвд олноор төвлөрүүлсэн нь тэднийг тусгаарлан сургахад хүргэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгай хөтөлбөрийг 2005 оноос боловсруулж эхэлсэн бөгөөд энэ хугацаанд хөгжлийн бэрхшээлийн тодорхой төрөлд суурилсан тусгай хөтөлбөрүүд боловсруулж иржээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үнэлгээг ГСТ-ний зорилтын хэрэгжилт /ахиц өөрчлөлт/-ээр үнэлэх зохицуулалт хийгдсэн боловч бодит байдалд энэ нь хэрэгждэггүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг (ГСТ-өөр сурдаггүй) бусад суралцагчдын нэгэн адил

7 Хүрэлбаатар. С. (2020). Монгол Улсын Боловсролын шинэчлэл ба гол асуудлууд, Нийгэм-эдийн засгийн төлөв байдлын үнэлгээ, Боть 5(4), 121-140, 135 дахь тал. (Khurelbaatar, S. (2020). Experience of the Mongolian Education Reform and Main Issues, Review of Socio- Economic Perspectives, Vol 5(4), 121-140, p. 135)



үнэлж байгаа талаар багш нар дурдаж байлаа. Угсаатны цөөнхийн бүлгийн хүүхдэд зориулсан сурах бичиг, удирдамж боловсруулж, бага боловсролын сургалтын хөтөлбөрийг казах, тува хэлнээ 2018 онд орчуулан 2019 онд багш нарт сургалт зохион байгуулжээ. Жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг сургалтын агуулга, хэрэглэгдэхүүн, материалд бүрэн тусгахыг зорьж байна.

### **Багш нарт дэмжлэг үзүүлэх**

Багш нар аливаа боловсролын тогтолцоог тодорхойлох чухал хүчин зүйлсийн нэг. Монгол Улсад багшийг ажилд авах, тогтвортой ажиллуулах, зэрэг дэв ахиулах үйл явц нь хэт улс төржсөн шинжтэй байгаа нь уг үйл явцыг сулруулахад нөлөөлж байна. Сургуулийн захирал хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд багшийг ажилд авах, ажлаас чөлөөлөх боломжтой. Гэвч багшийг ажилд авах, тогтвортой ажиллуулах талаарх зохицуулалтын тогтворгүй байдлын улмаас сайн бэлтгэгдсэн багш нар хот, суурин газарт төвлөрч хөдөө орон нутагт сайн багшийн хомсдол үүсжээ. Хэдийгээр хөдөө орон нутагт ажиллаж байгаа багш нар үндсэн цалингаас гадна санхүүгийн нэмэлт урамшуулал авах зохицуулалттай ч түүнийг үл харгалзан багш нар төв суурин газарт шилжин ажиллах сонирхол ихтэй байна.

Багш бэлтгэх их, дээд сургуулийн элсэлтийн босго оноо доогуур байгаа нь багш боловсролын хөтөлбөрт тааруу сурлагатай элсэгчид элсэхэд хүргэжээ. Төрийн болон хувийн өмчийн 40 гаруй их, дээд сургууль бага боловсролын багш бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлдэг ч зөвхөн хоёр сургуулийн сургалтын хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэн байна. Багш боловсрол нь дараах чиглэлийн сургалтад анхаардаг:

- (i) ердийн сургуулийн багш бэлтгэх сургалт;
- (ii) угсаатны болон хэлний цөөнхийн хүүхдүүдэд заах багш бэлтгэх нэмэлт сургалт;
- (iii) хараа, сонсгол, оюуны гэсэн гурван төрлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш бэлтгэх сургалт.

Монгол Улсын багшийн чанарыг сайжруулах асуудлыг шийдвэрлэхийн тулд дээд боловсролын сургалтын байгууллагын чанар, багш бэлтгэх хөтөлбөрийг алсыг харсан, оюутнуудын олон янз байдлыг цөмөө болгосон байдлаар боловсруулах чадавхыг бэхжүүлэхэд анхаарал хандуулах хэрэгтэй. Ерөнхий болон тусгай боловсролын багш нар ижил суурь хичээл судлах шаардлагатай бөгөөд тэгш хамран сургах боловсролын тогтолцооны талаар ижил үзэл бодолтой байхаас гадна ижил үнэт зүйлс, хандлага, мэдлэгтэй байх ёстой.

Тэгш хамран сургах боловсролын тогтолцоо нь ердийн болон тусгай боловсролын уламжлалт хосолмол тогтолцоотой үл нийцэх боловч тусгай боловсролын дэмжлэгт үйлчилгээ хэвээр байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд суралцах үйлд бүрэн дүүрэн оролцоход тулгарч буй саад бэрхшээлийг арилгахад дэмжлэгт үйлчилгээнүүдийг ашиглах хэрэгтэй.

Тэгш хамруулсан орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэхдээ тусгай боловсролын мэргэжилтнүүд ерөнхий боловсролын сургуулийн багш нар, эцэг эхчүүд болон сургалтын орчин дахь бусад талуудтай хамтран ажиллах шаардлагатай. Тусгай боловсролын мэргэжилтнүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд бусад суралцагчдын адил өндөр стандарт тавих, хүүхэд бүрд тохирсон хүлээлт үүсгэх, хүртээмжтэй байх хэрэгцээг хангахад ерөнхий боловсролын багш нартай хамтран ажиллах үүрэгтэй. Тиймээс тэгш хамран сургах боловсролын тогтолцоо дахь тусгай боловсрол нь боловсрол, сургалтын үйл явцыг суралцагчийн давуу тал болон хэрэгцээнд нийцүүлэн тохируулах нөхцөлийг бүрдүүлэхэд ерөнхий боловсролын багшид дэмжлэг үзүүлэхийг зорьдог. Үндсэн зорилго нь суралцахуйд чиглэсэн, нийгэм дэх тэгш хамралт, боловсролын хүртээмж, ололт амжилт, бие даасан байдал, сэтгэл хөдлөлийн тогтвортой байдал, адил тэгш боломжийг хөхиүлэн дэмжих болон цаашид үргэлжлүүлэн суралцах эсхүл сургууль төгссөний дараа ажил хөдөлмөр эрхлэх бэлтгэл хангах явдал. Хөгжлийн бэрхшээлтэй цөөхөн тооны хүүхэдтэй, тодорхой нөөц бололцоотойгоор тусгай сургуулийн тусгаарласан орчинд ажилласнаас тэгш хамруулсан орчинд ажиллах тусгай боловсролын мэргэжилтнүүд нь мэргэжлийн хувьд дараах өргөн хүрээний үүргийг хүлээдэг:

- хувь хүнд тохируулсан сурган хүмүүжүүлэх дэмжлэг үзүүлэх;
- сургалтын хөтөлбөрийг хувь хүнд тохируулан нийцүүлэх;
- сургуульд хамруулах үйл явцад тохируулга хийх;
- үнэлгээний үйл явцад тохируулга хийх;
- хувь хүнд зориулсан тусгайлсан сургалтын хөтөлбөр боловсруулах;
- технологийн дэмжлэг үзүүлэх.<sup>8</sup>

### **Ялгаатай байдлыг үнэлж, хүндэтгэх**

Монгол Улсын Үндсэн хуульд алагчлалын эсрэг зарчмыг тодорхой тусгажээ. Бүх хүн, хувь хүний онцлог шинжээс үл хамааран сурч боловсрох, үзэл бодлоо илэрхийлэх, саналаа тусгуулах эрхтэй. Мөн угсаатны ба хэл, соёлын цөөнх бүлгийн иргэдийн эх хэлээрээ суралцах, соёл урлаг, шинжлэх ухааны үйл

8 <https://www.european-agency.org/news/teacher-education-inclusion-profile-inclusive-teachers>

ажиллагаа явуулах эрхийг ч баталгаажуулжээ. Гэвч Монгол Улсын хууль тогтоомж, бодлого болон боловсролтой холбогдсон баримт бичгүүд нь “тэгш хамран сургах боловсрол”, “олон янз байдал”-ыг бүх нийтийн боловсрол бус харин тодорхой бүлгийн хүүхдийн боловсролын асуудалд хамааруулан авч үзэх хандлагатай байна. Үүний улмаас Монгол Улсад нийгмийн зарим бүлгийн суралцагчид (тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, малчдын хүүхэд, сүм, хийдэд шавилан сууж буй хүүхэд, үндэстний цөөнхийн хүүхэд болон гадаад улсад амьдарч байгаа монгол хүүхэд) боловсрол эзэмшихэд ялгаварлан гадуурхал болон нэмэлт саад бэрхшээлтэй тулгардаг байж магадгүйг хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч ялгаатай байдал нь хувь хүний оршихуйн тодотгол гэдгийг ойлгох ойлголт сул байна. Өөрөөр хэлбэл, хувь хүний онцлогоос үл хамааран янз бүрийн онцлог шинжтэй хүүхдүүдийг нийтлэг зүйлсийнх хүрээнд тусгайлсан ангилалд хамруулдаг бөгөөд улмаар тэднийг тусгайлсан тодорхой бодлого, арга хэмжээний зорилтот бүлэг болгон тодорхойлдог байна.

Бэлгийн цөөнх бүлгүүд (LGBTQIA)<sup>9</sup>-ийн талаарх ойлголт улс төр, нийгмийн хүрээнд шинэ тутам хэвээр байна. Мөн үндэстний цөөнх иргэдтэй холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилт сул байна. Бага боловсролыг хос хэлний сургалтын орчинд суралцагчдын сонгосон эх хэлээр соёл, түүхийн онцлогийг тусган эзэмшүүлэхээр бодлого (Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, 2014-2024, Монгол хэлний тухай хууль, 2016)-д заасан хэдий ч суурь боловсролын төгсөлтийн шалгалтын үр дүнгээс үзэхэд эх хэл нь монгол хэл биш сурагчдын сурлагын амжилтын үзүүлэлт доогуур байна.

Монгол Улсын боловсролын бодлогод жендэрийн эрх тэгш байдлын асуудал тууштай тусгагдсаар иржээ. Дотуур байртай сургууль нь Монгол Улсад удаан жилийн түүхтэй бөгөөд малчин өрхийн хүүхэд боловсрол эзэмшихэд чухал үүрэгтэй гэдэг нь хэдийнээ нотлогдсон. Гэвч өнгөрсөн хугацаанд эдгээр сургуулийн барилгын чанар муудах, ачаалал хэт нэмэгдэх, дэд бүтцийн хөгжил сул зэрэг асуудлаас гадна дотуур байранд амьдардаг хүүхдүүд хүчирхийлэл, дээрэлхэлтэд өртөж байна.

### **Суралцах үйлийг дэмжсэн ээлтэй орчин**

Монгол Улс 3.4 сая гаруй хүн амтай бөгөөд тэдний тал хувь нь нийслэл хотдоо амьдарч байна. Улаанбаатар хотын хувьд ихэнх сургууль хоёр ээлжээр хичээллэдэг, бүлэг дүүргэлтийн дундаж 31.5 бөгөөд цөөн тооны сургууль

9 Lesbian, Gay, Bisexual, Transgender, Queer, Intersex, Asexual

гурван ээлжээр<sup>10</sup> хичээллэдэг хэдий ч сургуульд шинээр элсэн орж буй сурагчдын эрэлтийг хангахын тулд хүчин чармайлт гарган ажилласаар иржээ. Гэтэл хөдөө орон нутагт нэг ангид ногдох хүүхэд аймгийн төвд 30.7, сумын сургуульд 18.2<sup>11</sup> байх бөгөөд хөдөө орон нутагт зарим мэргэжлийн багш ихээр дутагдаж байна. Хөдөөгийн олон цэцэрлэг, сургууль усан хангамж, ариун цэврийн байгууламж, эрчим хүчээр хангагдаагүй нь санаа зовоосон асуудлын нэг юм. Сургуулийн гадна байгаа хүүхдийн талаарх бодит тоо байхгүй, зөвхөн сургуульд сурч байгаад завсардсан хүүхдийн талаарх тоон мэдээг тайлагнадаг байна. Сургуульд огт ороогүй хүүхдийг статистикийн мэдээлэлд бүрэн бүртгэж чадахгүй байгаагийн дийлэнх нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байх магадлалтай юм.

Монгол Улс үндэсний сургалтын хөтөлбөрийг 1998 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ нь бүх суралцагчдад зориулагдсан хэдий ч агуулга, холбогдох материал, сурах бичгүүд нь өнгөрсөн хугацаанд олон удаа өөрчлөгдсөөр иржээ. Гэвч өөрчлөлтүүд нь сургуулийн өдөр тутмын амьдралд төдийлөн хэрэгжиж чадаагүй бөгөөд багш нар нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх талаарх сургалтад цаг тухайд нь хамрагдах нь ховор байна. Сургалтын хөтөлбөр академик мэдлэгт суурилсан, дундаж суралцагчид чиглэсэн, өрсөлдөөнт байдлыг дэмжсэн шинжтэй, бүх суралцагчийн сурах хэв маягийг харгалзан үзэх боломж олгох уян хатан чанар бага байна. Тодорхой бэрхшээлээр тусгайлан тохируулж 1950-аад онд боловсруулсан Оросын Холбооны Улсын сургалтын хөтөлбөрөөр Монголд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд суралцдаг байна. 2015 оноос хойш бүх сургуульд техник болон программ хангамж, техникийн дэмжлэг, багш нарын чадавхыг бэхжүүлэх зэргийг багтаасан мэдээлэл харилцааны орчин нөхцөл, дэд бүтцийн холболтыг сайжруулах чиглэлээр нэгдсэн арга хэмжээ хэрэгжүүлэхэд анхаарч иржээ. Энэхүү хөрөнгө оруулалт нь ялангуяа хот, хөдөөгийн хүүхдийн сурах боломжийн зөрүүг зарим талаар арилгах боломжтой ч холбогдох тайланд дурдсанаар мэдээлэл харилцааны технологийг сургах, сурах үйлд ашиглах үндэс суурийг системтэй бүрдүүлэхэд чиглэсэн боловсролын салбарын төлөвлөгөө байхгүй байна.

10 Хүрэлбаатар. С. (2020). Монгол Улсын Боловсролын шинэчлэл ба гол асуудлууд, Нийгэм-эдийн засгийн төлөв байдлын үнэлгээ, Боть 5(4), 121-140, 135 дахь тал. (Khurelbaatar, S. (2020). Experience of the Mongolian Education Reform and Main Issues, Review of Socio- Economic Perspectives, Vol 5(4), 121-140, p. 135)

11 өмнөхтэй ижил

### Үр дүнтэй шилжилт өөрчлөлт

Боловсролын түвшин бүрд төгсөлтийн хувь Монгол Улсад өндөр байгаа бөгөөд 2016 онд бага боловсрол эзэмшин төгссөн нийт хүүхдийн 99.0 хувь нь дунд боловсролд дэвшин суралцсан байна. Боловсролын бусад түвшин хоорондын шилжилтийн хувийг тодорхойлсон тоон мэдээлэл байхгүй, зөвхөн төгсөлтийн хувийг харах боломжтой юм.

Албаны холбогдох хүмүүсийн тайлбарласнаар боловсролын түвшин хооронд шилжих үйл явц маргаантай бөгөөд төлөвлөлт, сургах болон сурах үйл явцад хамаарах мэдээлэл ихэнхдээ түвшин хооронд алдагддаг байна. Ажил хөдөлмөрийн талбарт шилжихийн тулд их, дээд сургууль төгсөх, мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөр эсхүл “хоёр дахь боломж” олгох [албан бус] боловсролын хөтөлбөрийг дүүргэх шаардлагатай. Тайлан, судалгаанаас үзэхэд дээд боловсрол болон мэргэжлийн боловсрол, сургалтынтогтолцоо нь Монгол Улсын хөдөлмөр эрхлэлт, эдийн засаг, нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангаж чаддаггүй, сургууль завсардсан хүүхдүүд “хоёр дахь боломж” олгох албан бус боловсролын хөтөлбөрт хамрагдан сургуулиа төгсөх боломжтой ч олон тооны хүүхэд, залуус сургуулийн гадна байсаар байна. Тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангах, боловсролын үнэлгээг ялгаварлан гадуурхалтаас ангид байдлаар хийх болон амьдралын мөчлөг хоорондын шилжилт нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын хувьд нэн чухал алхам юм. Одоо ашиглаж байгаа ГСТ-ний загвар нь зааварчилсан шинж чанартай бөгөөд хүүхдийг төрөл бүрийн орчинд цогц байдлаар ажиглах боломжийг олгоогүйн зэрэгцээ урт, богино хугацааны зорилгыг боловсруулахад цаг хугацаа, орон зай хамарсан, ирээдүйд чиглэсэн байдлаар бус зөвхөн тухайн мөчийг авч үздэг байна.

### Түншлэлийг хүлээн зөвшөөрөх

Төрийн бус байгууллага болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд нь бүх суралцагчдыг урин дуудсан, тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн тэгш хамран сургах боловсролын тогтолцооны талаар нэгдмэл алсын хараатай байна. Дээрх байгууллагууд болон эцэг эхчүүдийн холбоо нь идэвхтэй хамтран ажилладаг болохоо дурдаад, хамтын ажиллагаагаа өргөжүүлж боловсрол, хамгаалал, эрүүл мэндийн үйлчилгээг хариуцсан төрийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх хүсэлтэй байдгаа илэрхийлсэн. Төрийн байгууллагынхан мөн адил иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллахын ач холбогдлыг онцлон тэмдэглэж, одоогийн техникийн чадавхын сул орон зайг нөхөхийн тулд тэдний мэргэжил, аргазүйн мэдлэг, туршлагыг ашиглахаар төлөвлөж байгаагаа ч дурдаж байлаа.

Гэвч эцэг эхчүүд сургууль, багшийн өдөр тутмын үйл ажиллагаа тэр дундаа суралцагчдын дунд гарсан зөрчлийг хэрхэн шийдвэрлэх талаарх мэдлэггүй байна. Сургууль хоорондын болон бусад чиглэлийн мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа сул, хамтран ажиллах соёл ч төлөвшөөгүй байна.

### Хяналт-шинжилгээ

Монгол Улсад Боловсролын салбарын мэдээллийн систем (БСМС)-ийг сургуулийн өмнөх боловсролоос ерөнхий боловсрол (насан туршийн боловсролын төвийг хамруулсан)-ын түвшин хүртэлх боловсролд хамаарах мэдээлэл цуглуулах нэгдсэн систем бүрдүүлэх зорилгоор хөгжүүлжээ. “Хэрэглэгч ба оролцогч талууд өдөр тутмын үйл ажиллагаандаа уг системийг ашиглах, шаардлагатай тайлан мэдээг хүссэн үедээ гаргах зорилгоор”<sup>12</sup> БСМС-ийг хөгжүүлсэн бөгөөд энэ систем нь багш, сургуулийн удирдах ажилтан болон эцэг эх, асран хамгаалагчдад нээлттэй байх боломжтой. Гэвч мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, их, дээд сургуулиуд энэ системийн бүрэлдэхүүн хэсэгт багтаагүй байна. Уг системээр цуглуулсан тоон мэдээллийг шийдвэр гаргах үйл явцад ашиглах явдлыг баталгаажуулахад өнөөгийн бодлогын орчин хангалттай бус байна. Систем нь суралцагчид, эцэг эхчүүдийг бодит цаг хугацааны мэдээллээр хангах боломжтой боловч байгууллагын чадавх сул байгаа нь түүнийг бүрэн ашиглахад саад болж байна.

Түүнчлэн боловсролын салбар болон бусад салбар хооронд мэдээлэл солилцох, нэгтгэх төлөвлөгөө байхгүй байна. Мэргэжлийн болон техникийн боловсролын асуудлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (БСМС нь Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдэлд) хариуцдаг тул ерөнхий боловсролоос мэргэжлийн болон техникийн боловсролд шилжиж байгаа суралцагчдыг мөшгөн судлах боломжгүй юм.

БСМС-ийн мэдээллийг бусад салбарын мэдээлэлтэй нэгтгэх нь чухал бөгөөд хөгжлийн бэрхшээлийн төлөв, аж байдлын мэдээ зэрэг боловсролын тогтолцооны чанарыг илэрхийлэх багц үзүүлэлтийг энэ системээр одоогоор цуглуулдаггүй<sup>13</sup>. БСМС-ээр сургууль завсардалтыг хянах боломжтой гэж үздэг ч түүнийг сургууль завсардалтаас сэргийлэхэд идэвхтэй ашигладаггүй байна. Хэдийгээр БСМС-д сул талууд байгаа ч боловсролын чанар,

12 НҮБ-ын Хүүхдийн Сангийн Зүүн Ази, Номхон далайн бүсийн төв (2020) Суралцагч нэг бүрийн мэдээллийг мөшгөх Боловсролын Удирдлагын Мэдээллийн Систем (БУМС)-ийн шинжилгээ (UNICEF EAPRO (2020) Review of Education Management Information Systems (EMIS) that Track Individual Student Data)

13 өмнөхтэй ижил; 13 дахь тал

Тогтвортой хөгжлийн зорилго 4 болон хөрөнгө оруулалтын ахицыг хянах үнэлгээний арга хэрэгсэл болохуйцаар хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой.

Хүүхдийн шилжилт хөдөлгөөн (хот, аймгийн төвийн сургуульд сурах эсхүл малчин эцэг эхдээ туслах зэрэг шалтгаанаас үүдсэн)-ийг улсын хэмжээнд мөшгөх боломж бүхий мэдээлэл цуглуулах механизм хангалтгүйн улмаас бодит тоон мэдээлэл гаргах нь бэрхшээлтэй, мөн сургуулиудын ачаалал ч өндөр байдаг байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаарх тоон мэдээлэл найдваргүй бөгөөд байгууллагуудын гаргадаг тайлан мэдээнүүд өөр хоорондоо зөрүүтэй байдаг.

### ● Зөвлөмж

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын Ерөнхий зөвлөмж 4-т тодорхойлсон тэгш хамран сургах боловсролын есөн үндсэн шинж чанарын хүрээнд хийсэн шинжилгээний үр дүнд суурилан бодлогын зөвлөмжийг боловсрууллаа.

Монгол Улс боловсролын тогтолцоогоо сайжруулахад хүчин чармайлт гаргасан хэмээн тайлагнасан ч<sup>14</sup> сүүлийн 10 жилийн хугацаанд гарсан хууль тогтоомж, бодлогын баримт бичиг нь ерөнхийдөө тогтолцоог бүхэлд нь бүх суралцагчдад хамааруулан сайжруулахаас илүүтэй тодорхой бүлгийн хүүхдүүдийн асуудлыг тусгайлан шийдвэрлэхэд чиглэжээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хамаарах шинээр батлагдсан хууль тогтоомж, бодлого, журам нь тооны хувьд харьцангуй олон боловч нийгмийн бусад эмзэг бүлгийн хүүхдэд хандуулах шаардлагатай анхаарлыг бууруулахад хүргэж байна. Энэ нь Монгол Улсад "тэгш хамран сургах боловсрол"-ыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулах асуудалтай шууд холбоотой гэж ойлгож ирсний улмаас тэгш хамран сургах боловсролыг сайжруулах зорилгыг хангахад чиглэсэн хууль тогтоомж, бодлогын хүрээнд хийсэн олон тооны өөрчлөлт, бодит байдал дахь үйл ажиллагааны хүрэх үр дүн нь<sup>15</sup> ихэнх тохиолдолд интеграцчилал болоход хүргэжээ<sup>16</sup>. Үүнээс гадна цөөнхийн бүлгийн асуудлыг авч үзсэн бодлого, хууль тогтоомж ч гэсэн хууль,

14 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц (2020)-ын 35 дугаар зүйлийн дагуу 2019 онд хүргүүлэх ёстой Монгол Улсын 2 ба 3 дахь үндэсний нэгдсэн тайлан илтгэл, CRPD/C/MNG/2-3, 2 дахь тал (Convention on the Rights of Persons with Disabilities (2020) Combined second and third periodic reports submitted by Mongolia under article 35 of the Convention pursuant to the optional reporting procedure, due in 2019. CRPD/C/MNG/2-3, p.2)

15 ЮНЕСКО (2020). Монгол Улс, Боловсролын бодлогын дүн шинжилгээ: насан туршийн суралцахуйн тогтолцоонд шилжих нь. Парис, Франц. ЮНЕСКО, 46 дахь нүүр (UNESCO (2020). Mongolia, Education policy review: towards and lifelong learning system. Paris, France. UNESCO)

16 өмнөхтэй ижил

захиргааны актын хэтийн зорилго, хүрээ нь БҮХ суралцагчдыг чанартай боловсролын тогтолцоонд хувь нэмэр оруулагчид гэж үзэхээс илүүтэйгээр цөөнхийн бүлгийнхний суралцагчдад давтлага хичээл болон тусгай үйлчилгээ хэрэгтэй гэсэн явцуу үзлийн хүрээнд хязгаарлагдсан байна.

### ЗӨВЛӨМЖ 1.

Тэгш хамран сургах боловсрол нь хүн бүрийн ажил үүрэгтэй хамааралтай юм. Тэгш хамран сургах боловсролын тогтолцоо нь тэгш хамруулсан нийгмийг бүрдүүлэхэд чиглэсэн аливаа улс үндэстний үүрэг амлалтын тусгал бөгөөд салбар хоорондын хамтын ажиллагаа уг тогтолцоонд чухал байдаг. Тэгш хамран сургах боловсролын тогтолцоог хөгжүүлэхэд Засгийн газрын бүх яамд боломжит нөөц бүрдүүлэх/зардал хуваалцах үүрэг хүлээх ёстой. Тэгш хамран сургах боловсролын тогтолцоог хөгжүүлэхэд дараах салбарын яамд, агентлаг хоорондын хамтын ажиллагаа, зохицуулалт шаардлагатай:

- боловсрол (сургах/сурах үйл ажиллагааг хариуцах);
- эрүүл мэнд (сургуулийн эрүүл мэнд, хүнс тэжээлтэй холбоотой асуудлыг хариуцах);
- нийгмийн хамгаалал (боловсролын салбарын ажилтнуудын тэтгэвэр, туслах хэрэглэгдэхүүн, сэргээн засахтай холбоотой асуудлыг хариуцах);
- санхүү (байгууллага хоорондын санхүүжилтийн зохицуулалтыг хариуцаж, хэрэгжилтэд шаардлагатай боломжит мөнгөн хөрөнгийг баталгаажуулах, Зөвлөмж 2);
- тээвэр (сурагчид гэртээ хамгийн ойр байх цэцэрлэг, сургуульд хүрэхийн тулд аюулгүйгээр/хүртээмжтэй зам, унаа тээврээр үнэ төлбөргүйгээр зорчих асуудлыг баталгаажуулах);
- дэд бүтэц (цэцэрлэг, сургууль, түүний ойр орчмын дэд бүтэц хүртээмжтэй бөгөөд зохистой байх явдлыг баталгаажуулах);
- мэдээлэл харилцааны технологи (21 дүгээр зууны эрэлт хэрэгцээнд нийцсэн, хүртээмжтэй мэдээлэл, технологийн зохистой дэд бүтцийг баталгаажуулах).

### ЗӨВЛӨМЖ 2.

Монгол Улсын Засгийн газар Тогтвортой хөгжлийн зорилго 4-ийн хүрээнд зөвлөсний дагуу боловсролд зарцуулах дотоодын нийт бүтээгдэхүүний хувийг 4-6 хувь болгож нэмэгдүүлэх хэрэгтэй. Боломжит бүхий л нөөцийг БҮХ нийтийг тэгш боломжтой, чанартай боловсролд хамруулахыг эрмэлзсэн



тэгш хамран сургах боловсролын тогтолцоог хөгжүүлэхэд зориулах ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хичээл заадаг багш нарт нэмэлт урамшуулал олгох тогтолцоог бий болгох нь тусгаарлалтыг дэмжиж, тэгш хамруулсан соёл төлөвшүүлэхэд саад болж буй “тусгай мэргэшил”-ийн өнөөгийн хараат байдлыг улам бүр идэвхжүүлэх болно. Цэцэрлэг, сургуульд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй болон үндэстний цөөнхийн хүүхдэд нэмэлт санхүүжилт олгохоос илүүтэйгээр сургуулийн тухайн үеийн нөөц боломж, хэрэгцээ шаардлагад үндэслэн санхүүжилт олгодог холимог-санхүүжилтийн загвар ашиглан бүх цэцэрлэг, сургууль зохистой нөөцтэй байх явдлыг баталгаажуулах хэрэгтэй. Санхүүжилт илүү шаардлагатай сургуулиуд (тухайлбал, хотын захын, алслагдмал орон нутгийн, сургууль завсардсан хүүхдүүд олонтой, үндэстний/хэлний цөөнхийн бүлгийн хүүхдүүд олонтой г.м.)-ын хувьд санхүүжилтийг хэрэгцээ шаардлагатай нь уялдуулан тооцох хэрэгтэй. Жишээ болгон Тусгай хэрэгцээ ба тэгш хамран сургах боловсролын төлөөх Европын Агентлагийн санал зөвлөмжийг дараах холбоосоос танилцах боломжтой: <https://www.european-agency.org/activities/fpies/financing-policy-issues-goals-and-objectives>.

Мөн хүний болон орчны нөөцийг хангалттай, хүртээмжтэй байлгахын тулд тусгайлсан санхүүжилтийг хуваарилах шаардлагатай. Сайн мэргэшсэн мэргэжилтний мэргэжил, арга зүйн дэмжлэгийг авах тохиолдолд дэмжлэгийн энэ үйлчилгээг олон цэцэрлэг, сургууль, багш нарт сургалтын байгууллага дундын үйлчилгээ байдлаар хүргэх боломжтой байх явдлыг баталгаажуулах ёстой. Энэ тохиолдолд хөрөнгө нөөцийг дундаа хэрэглэхээс гадна уг үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэхийн тулд суралцагчид, багш нарт үзүүлэх дэмжлэгийн үйлчилгээг явуулын багаар гүйцэтгүүлэх боломжит хувилбарыг авч үзэх хэрэгтэй.

### ЗӨВЛӨМЖ 3.

Монгол Улсын Засгийн газар нь иргэний нийгэмтэй зөвлөлдөн Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц (Ерөнхий зөвлөмж 4)-оор тус тус хүлээсэн амлалтаа тусгасан Боловсролын тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгтэй. Хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомж, бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулахаас илүүтэйгээр Боловсролын тухай хуулийн төсөлд интеграцчилал ба тэгш хамралт хоёрын үндсэн ялгааг тодорхойлж, дэмжлэгийн олон давхаргат тогтолцоо бий болгох нөхцөлийг бүрдүүлснээр сургууль бүр суралцагчдынхаа давуу тал, хэрэгцээ шаардлагад тохируулан зохистой байдлаар хариу үйлдэл үзүүлэх боломжтой болно. Өнөөгийн тогтолцооны

хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг интеграцчилах явдалд ач холбогдол өгсөн хэвээр байх нь тусгаарлалтыг илүү дэмжихэд хүргэж, тэгш хамран сургах боловсролын төлөөх үйл хэрэг нь амжилтад хүрэхгүй байна гэсэн буруу сэтгэгдэл төрүүлж болзошгүй юм.

#### **ЗӨВЛӨМЖ 4.**

Тэгш хамруулсан сургуулийн соёлыг хөгжүүлэхгүйгээр амжилтад хүрэх боломжгүй билээ. Иймд Монгол Улсын Засгийн газар хууль тогтоомж, бодлогоос гадна боловсролд бүрэн хамрагдахад тулгарч буй бүхий л саад бэрхшээлийг арилгах замаар өөрийн соёлын онцлог байдлыг сурталчлан дэмжсээр байх хэрэгтэй. Тэгш хамран сургах боловсрол нь тогтолцооны бүхий л бодлого, практик үйл ажиллагааны суурь байх бөгөөд бүх суралцагчдыг нэр хүндтэй гэдгийг нь хүлээн зөвшөөрч хүндэтгэлтэй хандах ёстой. Ялгаварлан гадуурхахгүй байх болон адил тэгш боломж (Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцод заасны дагуу)-ийг тогтолцоонд бүхэлд нь хангах шаардлагатай.

#### **ЗӨВЛӨМЖ 5.**

Тэгш хамруулсан соёлыг бий болгох арга замын нэг нь суралцагчдын сурах боломжийг хязгаарласан (сургалтын агуулгыг хөнгөвчлөх) нэр өгч ангилах явдлыг халах явдал юм. Боловсролын тухай хуулийн төсөл нь тусгаарлалт, интеграцчилалд хүргэдэг энэхүү хаяглан ангилах хандлагаас татгалзаж, хувь хүнд чиглэсэн арга зүй, суралцагч бүрд өөрийн давуу тал, хүсэл эрмэлзэлийнхээ дагуу хөгжихөд шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх дэмжлэгийн олон давхаргат тогтолцоог дэмжих шаардлагатай.

#### **ЗӨВЛӨМЖ 6.**

Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц болон суралцахуйн түгээмэл загварт суурилсан тэгш хамран сургах боловсрол нь хүүхэд бүрийг суралцах чадвартайг хүлээн зөвшөөрдөг бөгөөд суралцагч бүрийн хувьд өндөр стандарт, хүлээлт тавьдаг. Тиймээс Боловсролын тухай хуулийн төсөл нь суралцагчдын сурах ялгаатай хэв маяг, үйлдлийн чадваруудыг тодорхойлж, сурах урам зоригийг нь өдөөн идэвхжүүлдэг ялгаатай аргуудад нийцүүлэн суралцах үйлийг дэмжих асуудалд анхаарал хандуулах шаардлагатай. Суралцахуйн түгээмэл загварыг мэдээлэл, харилцаа холбооны хувьд өргөжүүлэн авч үзэх ёстой. Ингэхдээ

ихэнх тохиолдолд хэвлэмэл хэлбэрээр байдаг зүйлсийг өөр хувилбарт хэлбэрээр боловсруулах цахим материал, техник болон програм хангамжийг хүртээмжтэй байлгахад илүү ач холбогдол өгөх хэрэгтэй. Үүний зэрэгцээ материаллаг байдал болон мэдээлэл харилцааны хувьд тулгарч буй саад бэрхшээлийг арилгахад анхаарах шаардлагатай. Төрөл бүрийн орчин дахь дэд бүтцийн хүртээмжтэй байдлын хувьд (жишээ нь, GAATES Accessibility Continuum – 17 дахь тал) суралцагчид цэцэрлэг, сургуульдаа хэрхэн хүрдэг (хотын төлөвлөлт дизайн, замын хөдөлгөөн), сургуулийн барилга байгууламжид хэрхэн нэвтэрдэг, өдрийн турш цэцэрлэг, сургууль дотроо хэрхэн хөдөлгөөнд оролцдог, анги танхим дахь үйл ажиллагаа, усан хангамж, ариун цэврийн байгууламж нь ямар нөхцөл байдалтай байдаг болон тоглох, чөлөөт цагаа өнгөрөөх орон зай ямар байдаг зэрэгт анхаарал хандуулах шаардлагатай<sup>17</sup>.

### ЗӨВЛӨМЖ 7.

Хувь хүнд чиглэсэн суралцахуйн арга хандлагыг дэмжсэн сургалтын хөтөлбөр нь уян хатан байх шаардлагатай. Боловсролын тухай хуулийн төслийг боловсруулахтай зэрэгцэн суралцахуйн түгээмэл загварын зарчим, суралцагчдын сурах хэв маяг, хүсэл эрмэлзэлд нь тохирсон соёлын хувьд нийцтэй агуулга болон заавал эзэмших боловсролыг дүүргэх олон арга замд суурилсан сургалтын уян хатан хөтөлбөр боловсруулах хэрэгтэй.

### ЗӨВЛӨМЖ 8.

Тэгш хамран сургах боловсролын тогтолцоонд багш нар бол БҮХ суралцагчдад заах болон дэмжлэг үзүүлэхэд бэлтгэгдсэн байх ёстой. Багш нар тэгш хамран сургах боловсролын бодлогыг хэрэгжүүлэх гол түншүүд бөгөөд нэг багшид ногдох хүүхдийн тоо, мэргэжлийн бус туслах багш зэрэг хүчин зүйлсээс илүү чухал юм. Иймээс багш нарын хүсэл эрмэлзэлийг дэмжиж, хүчин чармайлтыг нь урамшуулсан арга хэрэгслээр тэднийг хангах хэрэгтэй.

Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ) нь багш болохоор бэлтгэгдэж буй окутан, цэцэрлэг, сургуульд ажиллаж байгаа тусгай чиглэлээр

17 НҮБ-ын Хүүхдийн Сан (2014) Сургууль болон суралцах орчны хүртээмж I – Барилга байгууламж болон мэдээлэл, харилцааны хүртээмж – вэбинар 10 Арга зүйн гарын авлагын багц, [https://www.unicef.org/eca/sites/unicef.org.eca/files/IE\\_Webinar\\_Booklet\\_10.pdf](https://www.unicef.org/eca/sites/unicef.org.eca/files/IE_Webinar_Booklet_10.pdf) холбоосоор 2022 оны 7 дугаар сарын 5-нд мэдээлэл авсан. (UNICEF (2014) Access to School and the Learning Environment I – Physical, Information and Communication – webinar 10 Companion Technical Booklet, [https://www.unicef.org/eca/sites/unicef.org.eca/files/IE\\_Webinar\\_Booklet\\_10.pdf](https://www.unicef.org/eca/sites/unicef.org.eca/files/IE_Webinar_Booklet_10.pdf))

мэргэшсэн багш гээд бүхий л багш нарыг өөр хоорондоо ялгаатай хэрэгцээ шаардлагатай, өөр өөр чадвар, сонирхол бүхий нэг ангийн бүх хүүхдэд заах ур чадвартай болгон бэлтгэхийн тулд Profile of Inclusive Teachers/Тэгш хамран сургадаг багшийн тодорхойлолт (суралцагчдын олон талт байдлыг хүндэтгэх, бүх суралцагчдад дэмжлэг үзүүлэх, бусадтай хамтран ажиллах, багш өөрөө насан туршийн суралцагч байх)-ын дагуу сургахад анхаарал хандуулах шаардлагатай. Тэгш хамруулсан арга зүйн хүрээнд тодорхой бүлгийн хүүхдүүдийг 'тусгай' хэмээн нэрлэсэн, тусгай багш нар эсхүл төвүүдээр дамжуулан тэдэнд боловсрол олгохын оронд бүх багш нар өөрийн хариуцсан ангийнхаа бүх суралцагчийн суралцахуй болон сайн сайхан байдалд хариуцлага хүлээж байдаг. Бүх багш нар тэгш хамруулсан багш байх ёстой билээ.

### ЗӨВЛӨМЖ 9.

БШУЯ нь сургуульд зөвхөн сайн бэлтгэгдсэн ур чадвартай мэргэжилтнүүд ажиллах явдлыг баталгаажуулахын тулд багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх бүх хөтөлбөрийг удирдлага зохицуулалтаар хангах ёстой. Тусгай боловсрол болон хос хэлний боловсролын чиглэлээр мэргэшихийн тулд өмнө нь ердийн сургуульд таваас доошгүй жил ажилласан, олон төрлийн суралцагчтай ажиллах сурган хүмүүжүүлэх ухаан, заах арга зүйн сайн туршлагатай багш байх шаардлагатай. Эдгээр багш, мэргэжилтнүүдийг бусад хүмүүстэй хамтран ажилладаг чадвартай болгон бэлтгэх нь нэн чухал билээ. Зөвхөн ингэж бэлтгэгдэж чадсан үед л тэд багш нарыг бүх суралцагчидтай ажиллахад нь хангалттай дэмжлэг үзүүлэх боломжтой болно.

### ЗӨВЛӨМЖ 10.

Олон талт байдлын асуудлыг шийдэх, бүх суралцагчийг адил тэгш байдлаар үнэлж хүндэтгэх явдлыг хангахын тулд бүх сургууль, бүх анги танхим дахь сургах/сурах үйл явцыг суралцахуйн түгээмэл загварын дагуу төлөвлөх хэрэгтэй. Суралцахуйн түгээмэл загвар нь олон давхаргат дэмжлэгийн тогтолцоо (Зөвлөмж 5) болон ялгаатай сургах арга зүйн талаарх мэдлэг, үйл ажиллагааны суурь байх ёстой.

### ЗӨВЛӨМЖ 11.

Хүүхдүүд болон тэдний эцэг эхчүүдийг цэцэрлэг, сургуулийн удирдлагатай харилцах, боловсролын орчин (сургалтын байгууллагын барилга байгууламж,

тээвэр, дотуур байр зэргийг хамруулж ойлгоно)-д гарсан ялгаварлан гадуурхал, хүчирхийллийн тохиолдлыг мэдээлэх боломж олгосон хүүхдэд ээлтэй, ил тод, нээлттэй гомдол мэдээлэх тогтолцоо бий болгох хэрэгтэй. Хүүхдийн асуудалд ач холбогдол өгч, хүчирхийллийн бүх тохиолдлыг Хүүхэд хамгааллын хуулийн дагуу хянан шийдвэрлэх шаардлагатай.

### ЗӨВЛӨМЖ 12.

Олон давхаргат дэмжлэгийн тогтолцоо нь суралцахуйн түгээмэл загвараас гадна хүүхдэд зориулсан, боловсруулах үйл явцад тэднийг оролцуулсан эерэг зан үйлийн удирдлагын тогтолцоог өөртөө багтаасан байх ёстой. Орчин болон арга хандлага нь хүүхдэд ээлтэй байх нь зайлшгүй шаардлагатайн нэгэн адил сургалтын орчны барилга байгууламжийн хүртээмжтэй байдал ч чухал билээ.

### ЗӨВЛӨМЖ 13.

Хүүхэд бүр анх төрөлх хэлээрээ сургах/сурах үйл явцтай танилцдаг бөгөөд монгол хэл сурах үйл явц руу үе шаттай шилждэг байх суралцахуйд ээлтэй орчин бүрдүүлэх нь чухал юм. Монгол Улсын Засгийн газар монгол хэлээс гадна цөөнхийн гурван хэл (казах, тува, дохионы хэл)-ийг хүндэтгэсэн, цаашдын хөгжлийг нь дэмжсэн хос хэлний зохистой тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай. Тува, казах угсаатны бүлгийн хүүхдүүдэд Латви Улсад мөрдөж буй тогтолцоотой төстэй байдлаар 1-6 дугаар ангид судлах хичээлийн 50-аас доошгүй хувийг эх хэлээр нь заах бөгөөд бүх хичээлийн агуулгад хамаарах тоглоом болон хүмүүс хоорондын харилцаанд монгол хэлийг ашиглах, 7-9 дүгээр ангид судлах хичээлийн 80-аас доошгүй хувийг монгол хэлээр заах, ялангуяа монгол хэлээр шалгалт авдаг хичээлд онцгой анхаарал хандуулахыг санал болгож байна<sup>18</sup>. Хоёр дахь хэл нь монгол хэл бүхий хүүхдүүд монгол хэлийг зөвхөн хичээлээр судлах төдийгүй үндэсний хэмжээний харилцааны хэрэгсэл болохын хувьд судлах шаардлагатай. Үүний нэгэн адил сонсголгүй хүүхдүүд дохионы хэлийг бусад хүүхдээс

18 Хууль тогтоомжоор дамжуулан ардчиллыг дэмжих Европын Комисс (Венисийн Комисс) (2020) ЦӨӨНХИЙН ХЭЛЭЭР БОЛОВСРОЛ ОЛГОХ ХУУЛЬД ОРУУЛСАН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХ ЛАТВИ УЛСЫН ДҮГНЭЛТ 123 дахь чуулганы нэгдсэн хуралдааны дүгнэлт (Opinion n° 975/2020)-ийг өөрчлөн гаргасан журмаар Венисийн Комиссоос 2020 оны 6 дугаар сарын 18-нд баталсан, Старсбург. (European Commission for Democracy through law (Venice Commission) (2020) LATVIA OPINION ON THE RECENT AMENDMENTS TO THE LEGISLATION ON EDUCATION IN MINORITY LANGUAGES adopted by the Venice Commission on 18 June 2020 by a written procedure replacing the 123rd Plenary Session (Opinion n° 975/2020). Starsbourg.)

тусдаа бус харин бусад (сонсголгүй болон хэвийн сонсголтой) хүүхдүүдтэй хамт сурах боломжтой байх ёстой. Тэгш хамруулсан соёлыг бодит утгаар нь баталгаажуулах явцад дохионы хэлийг үндэсний нэг хэл болгон хөгжүүлэх нь хэвийн сонсголтой хүүхдүүд дохионы хэлээр харилцах хүсэл эрмэлзэлийг бий болгон, түүнийг сурах шаардлагыг бий болгоно. Мөн сонсголгүй хүүхдүүд ерөнхий болон мэргэжлийн боловсрол эзэмшиж, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвартай байхын тулд заавал бичиг үсэг сурсан байх ёстой.

#### **ЗӨВЛӨМЖ 14.**

Сургууль бүр суралцагчийн, эцэг эх, асран хамгаалагчийн зөвлөл болон бусад бүтцийг идэвхжүүлэх эсхүл шинээр бий болгож олон нийтийн оролцоог хангасан сургуулийн соёлыг бий болгоход анхаарах хэрэгтэй. Хүүхдийн эрхийн тухай конвенцоор хүлээсэн амлалтаа биелүүлэхийн тулд БШУЯ суралцагчдад бие биенээсээ суралцах, сургуулийн үйл ажиллагаанд оролцох боломж олгоход шаардлагатай мэдлэг, ур чадвараар багш нарыг хангахад анхаарах хэрэгтэй.

#### **ЗӨВЛӨМЖ 15.**

Бүх суралцагчид, ялангуяа ГСТ-өөр хичээллэдэг суралцагчдад боловсролын нэг түвшнээс нөгөө түвшинд шилжих шилжилтийн үед нэмэлт дэмжлэг хэрэгтэй байдаг. БШУЯ энэ зөвлөмжийн 6, 7-д нийцүүлэн хүүхэд бүрийн урт хугацааны зорилго (зорилго нь ирээдүйд чиглэсэн)-ыг ГСТ-нд тусгаж шилжилтийг хоёр жилийн өмнөөс төлөвлөсөн байх явдлыг баталгаажуулах шаардлагатай. Дунд, ахлах ангийн суралцагчийн ГСТ-нд техникийн болон мэргэжлийн сургалт, дээд боловсролд шилжин сурах, ажил хөдөлмөр эрхлэх хувилбарыг судлах асуудлыг төлөвлөж, ерөнхий боловсрол төгсөж байгаа суралцагч насан туршдаа суралцах үйл явцын дараагийн үе шатанд амжилттай шилжихэд анхаарал хандуулах хэрэгтэй.

#### **ЗӨВЛӨМЖ 16.**

Суралцахуйн түгээмэл загварт суурилсан тэгш хамран сургах боловсролын тогтолцоо нь Португал Улсын туршлагатай адил олон давхаргат дэмжлэгийн тогтолцоогоор олгодог сонголтот болон нэмэлт дэмжлэгийг багтаадаг. ГСТ нь зөвхөн сургах/сурах үйл явцыг зааварчилгаар хангах бус харин боловсролын түвшин хооронд амжилттай шилжихэд нөлөө үзүүлдэг

үнэлгээний удирдамжаар хангадаг байх явдлыг БШУЯ-аас баталгаажуулах шаардлагатай.

### ЗӨВЛӨМЖ 17.

Тэгш хамран сургах боловсрол нь хүн бүрийн ажил, үүрэгтэй хамааралтай гэдгийг дээр дурдсан. Иймээс тэгш хамран сургах боловсрол нь сургуулийн дөрвөн ханаар хязгаарлагдах биш харин олон нийтийг сургуулийн үйл ажиллагаанд оролцуулдаг, сургуулийн хамт олон тэдний үйл хэрэгт ч оролцдог тогтолцоо юм. Монгол Улсад тэгш хамран сургах боловсролын арга зүйн чадавх дутмаг гэдгийг хүлээн зөвшөөрч БШУЯ орон нутаг, үндэсний болон олон улсын бүх түншүүдийн хамт Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын Ерөнхий зөвлөмж 4-тэй нийцсэн тэгш хамран сургах боловсролын тогтолцоог бүрдүүлэхийн төлөөх нэгдмэл нэг зорилгын хүрээнд ажиллах явдлыг баталгаажуулсан бүтцийг бий болгох хэрэгтэй.

### ЗӨВЛӨМЖ 18.

БШУЯ, бусад салбарын төрийн байгууллага тэгш хамран сургах боловсролыг дэмждэг төрийн бус байгууллага болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагын дэмжлэг туслалцааг албан ёсоор авах хэрэгтэй. Цөөн тооны хүүхдүүд эсхүл гэр бүлүүдэд дэмжлэг үзүүлж ажилладаг төрийн бус болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд олон байгаа ч дэмжлэгийн тогтолцоог нарийвчлан хөгжүүлснээр илүү тогтвортой бөгөөд найдвартай болох юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролд хамрагдалтыг дэмжих болон тэгш хамран сургах боловсролын талаарх эцэг эх, асран хамгаалагчийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр цэцэрлэг, сургуулийн түвшинд эцэг эхийн зөвлөлийг шинээр байгуулах эсхүл одоо байгаа зөвлөлийн үйл ажиллагааг өргөжүүлэн сайжруулах боломжтой.

### ЗӨВЛӨМЖ 19.

БШУЯ-ны хувьд бэлэн байгаа тоон мэдээлэл, өгөгдлийг бусад яамдтай хамтран хянан баталгаажуулах нь чухал бөгөөд шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл цуглуулахад БСМС гол үүрэгтэй юм. Цэцэрлэг, сургуульд суурилсан тоон мэдээлэл цуглуулахад хариуцлага хүлээн ажиллах чиглэлээр багш нарыг сургах нь бодит мэдээлэлд үндэслэн орон нутгийн түвшний бодлого, санхүүжилттэй холбогдсон шийдвэр гаргахад нөлөөтэй. Түүнээс гадна БСМС нь сургалтын байгууллага, айл өрхүүдийн

хоорондын гүүр болж, багш нар, сургуулийн удирдлагатай эцэг эхчүүд харилцах хэрэгсэл болох боломжтой.

### ЗӨВЛӨМЖ 20.

Тэгш хамран сургах боловсролын тогтолцоо руу чиглэсэн ахиц дэвшлийн талаарх хяналт-шинжилгээ, үнэлгээг эрх эдлэгчдийн утга төгөлдөр оролцоогүйгээр хийх боломжгүй юм. Олон нийт, хүүхдүүд, эцэг эхчүүд тэгш хамран сургах боловсролын үндсэн есөн шинж чанарын талаар мэдлэгтэй байх, чанартай боловсролыг хүлээн зөвшөөрөхийн тулд юуг анхаарах ёстойг ч мэддэг байх ёстой. Үүний дараа тэд орон нутгийн түвшинд цэцэрлэг, сургуулиудтай санал солилцох, сургах/сурах орчныг хэрхэн сайжруулах талаар зөвшилцөх боломжуудыг бүрдүүлэх ёстой.

Монгол Улсад тэгш хамран сургах боловсролын тогтолцоог бүрдүүлэхийн тулд дээр дурдсан зөвлөмжийг өөрийн орны хам нөхцөл болон хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж, бодлогод нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатай. Энэхүү хүчин чармайлтыг Засгийн газрын зүгээс удирдан чиглүүлж, БШУЯ, Боловсролын ерөнхий газар болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлэх хэрэгтэй.



